НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

# БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

# ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

1.2. Төрөөс баримтлах бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн

1.3. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжилт зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажил

1.4. Улсын болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт

1.5. Бүсчилсэн хөгжлийн бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн

1.6. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Нийслэлийн Засаг даргын хооронд 2019 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний соёл, урлагийн чиглэлээрх заалтын хэрэгжилт

1.7. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

1.8. Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн нийслэл болон тухайн байгууллагуудад холбогдолтой заалтын хэрэгжилтийн тайлан

2.2. НИТХ-ын болон тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилтийн тайлан

2.3. Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн тайлан

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт

3.2. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа

3.3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл

3.4. Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

3.5. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, архив албан хэрэг хөтлөлт

3.6. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа

3.7. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн байдал

3.8. “Нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д 2019 онд гаргасан тайлан, мэдээ

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал

4.2. Төсөв, санхүүгийн ил тод байдал

4.3. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

4.4. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

## ТАВДУГААР БҮЛЭГ. НИЙСЛЭЛИЙН ХҮН АМД ҮЗҮҮЛЭХ СОЁЛ, УРЛАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ЧАНАРТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

5.1. Шинээр санаачилсан ажил

5.2. Бусад ажил

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Соёл, урлагийн газар нь 2019 онд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд соёл, урлагийн чиглэлээр тусгагдсан заалтуудыг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг хангаж ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар нь Монгол Улсын төрөөс Соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/826 дугаарын захирамжаар батлагдсан дүрэм, 2016 оны 08 дугаар 31-ний өдрийн А/635 дугаарын “Агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” захирамжийн дагуу Соёлын хэлтэс, Урлагийн хэлтэс гэсэн 2 хэлтэс 14 хүний орон тоотой ажиллаж байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж, түүнд үндэслэн ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Тус газар нь шинэчлэгдсэн хууль, тогтоол шийдвэрийг холбогдох дүрэм, журамдаа тусган баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хуучин мөрдөгдөж байсан дүрэм, журмыг хүчингүй болгож, байгууллагын цахим сайтад шинэчлэн байршуулж, иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй үйлчилж байна. Мөн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг 2019 оны 05 дугаар сарын 31-ний А/28 дугаарын тушаалаар байгуулж, МУ-ын Засгийн газрын 36 дугаар тогтоолоор батлагдсан “Стартеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын дагуу төслийг боловсруулсан. Байгууллагуудын нэгж хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор чиг үүргийн хуваарилалтад дүн шинжилгээ хийж, ТАЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж төслийг Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн.

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ



**1.1 Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" -д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн:**

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болох зорилтын дэвшүүлсний дагуу Улаанбаатар хот зүүн хойд Азийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилтыг дунд хугацааны бодлогын баримт бичигтээ тусган жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Соёл урлаг, спорт, аялал жуулын цогц арга хэмжээг төлөвлөн нийслэлийн төсвийн тодорхой хувийг зарцуулан хэрэгжүүлж байна.

**1.2 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын зорилтын хэрэгжилт:**

***Үндэсний хөгжилд соёл урлагийн эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:***

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр улс орон даяар уламжлагдан зохион байгуулагддаг **"Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"**-үүдээр дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:



Тус газрын Улаанбаатар хотын Нийтийн төв номын сан Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сан "Эх хэлээ дээдэлье" уран илтгэлийн уралдааныг уламжлал болгон анхны жилдээ зохион байгуулж шилдэг уран илтгэгчийг шалгаруулсан. Оюутан, сурагчдыг өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, эх болсон Монгол хэлээрээ уран яруу, зөв ярих дадал олгох, эх хэлээ дээдлэх ухамсар олгох, зэрэг өөрчлөлтийг бий болгож соён гэгээрүүлэхэд зорилготой. Гадаад үг хэллэг оруулахгүй, Монгол хэлээрээ цэгцтэй, ойлгомжтой ярьж бичих гэсэн ерөнхий шаардлага хангасан 36 оюутан, сурагчдаас шилдэг 8 сурагч, оюутныг сонгон илтгэлийг яриулан шилдэг 3 илтгэгчийг шалгаруулж өргөмжлөл, ном, тусгай байрын шагналаар шагнаж урамшууллаа.

**"Алтан үсгийн цоморлиг" уралдаан:**



Уралдаанд 15 бүтээл ирснээс тэргүүн байранд ШУТИС График дизайны 1 дүгээр курсын оюутан Б.Өсөх-Эрдэнэ, дэд байранд Санхүү эдийн засгийн их сургууль 3 дугаар дамжааны оюутан М.Данзанпэрэнлэй, гутгаар байранд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Ерөнхий Боловсролын сургуулийн 11а ангийн сурагч Б.Гийхнаран шалгарсан.



**"Монгол өв соёл, үнэ цэн"** лекцийг Урлаг судлалын магистр Х.Эрдэнэбаяр оюутан сурагчдад өсөхөөс төрсөн үндэсний хэл мартаж болшгүй соёлын сайхныг мэдрүүлсэн, монгол хэл соёлоороо бахархах, ном эрдмийг эрхэмлэх, монгол бичгийн уран бичлэгийн тухай ярьж, үндэсний эх хэл бичгээрээ бахархаж явахын үнэ цэнийг уншигчдад ойлгуулан таниулсан

сонирхолтой лекцийг хийсэн. "Бичиг үсгийн соёл" сэдэвт уулзалтыг Монгол улсын зөвлөх багш, “Ертөнц” бүрэн дунд сургуулийн Монгол хэл уран зохиолын багш А.Цэнгэлтэй хийлээ. Уулзалтанд 50 дугаар сургуулийн 9в ангийн 46 сурагч оролцлоо. Үндэсний бичиг үсгийн баяраар “Идэр” их сургуулийн монгол хэл, уран зохиолын багш, хэл судлалын магистр Д.Уянга, эх хэлээ эрхэмлэн дээдэлж, бичиг соёлын дурсгалыг сурталчлах зорилгоор ХУД-ийн ЕБС-ийн 9-12 ангийн нийт сурагчдад “Яагаад бидэнд Монгол бичиг хэрэгтэй вэ?” сэдвээр сургалт хийлээ. Уулзалт сургалтад 139 сурагч хамрагдсан. Мөн МУ-ын УГЗ, Төрийн шагналт асан МУ-ын төрийн сүлд бүтээгч Ц.Ойдовын уйгаржин монгол бичгээр бичсэн уран бичлэгийн 14 ширхэг бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчлав. Зураач О.Андимана “Монгол бичиг минү” уйгаржин монгол бичиг, таталган бичиг, бийрэн бичлэгийн талаар каллиграфийн хичээлийг оюутан сурагчдаар муутуун цаасан дээр бичүүлж, 5 уншигчийг шалгаруулж дурсгалын зүйл гардуулав. ЕБС-ийн СБД-ийн 16 дугаар сургуулийн нарийн бичгийн дарга А.Бямбасүрэнгээр ахлуулсан 11 дүгээр ангийн 50 сурагч, нийт 65 хүн хамрагдсан. "Эх хэлний тань мэдлэгт" "Монгол бичгийн түүхээс "үзэсгэлэнг 10 ш ном, 10 ш хэв 14 ш бүтээлээр гаргаж сурталчилсан. Уйгаржин монгол бичгээр 20 ширхэг ном, Монголчуудын бичиг үсгийн түүхийг 10 ширхэг хэвлэмэл хуудсаар сурталчлав. Үүнд: Монгол бичиг, Соёмбо үсэг, Дөрвөлжин үсгийн гарал үүслийг тухай мэдээлэл гаргав. Үндэсний бичиг үсгийн баяр арга хэмжээнд нийт 28 ш бүтээл, 30ш ном, 20ш хэвлэмэл хуудсаар үзэсгэлэн гаргаж, 2 удаагийн уралдаан тэмцээнд 41 оюутан сурагчид оролцож, ЕБ-ын 16, 50, 111 дүгээр сургуулийн 9-12 ангийн 96 сурагч, ИЗИС-ийн Идэр ИС-ийн 66 оюутан оролцсон. Нийт 181 хүн хамрагдлаа.



***Соёлын үнэт зүйлийг иргэд бүтээн бий болгох, хүртэх, эзэмших, орчин нөхцөл бүрдүүлэх зорилтын хүрээнд:***

Соёлын үнэт зүйлийг иргэд бүтээн бий болгох, хүртэх эзэмших орчин нөхцөлийг хангах зорилго бүхий хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлуудыг нийслэлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байна. Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулах зорилго бүхий “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг нийслэлд хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

***Соёлын өвийг хадгалж, хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх зорилтын хүрээнд;***

Соёлын биет болон биет бус өв, баримтат өвийг хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, сэргээн засварлах талаар нийслэлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын А/427 тоот захирамжаар Улаанбаатар хотын нийтийн төв номын санд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 500 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр шийдвэрлэсэн. Үүнээс он дамжин хийгдсэн Хан-Уул дүүргийн Соёлын ордны номын уншлагын жишиг танхимын тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэхээр шалгарсан “Харцагат Уул” ХХК, салбар номын сангуудын номын фондын баяжилтын ном нийлүүлэхээр гэрээ байгуулсан “Интерном” ХХК-ийн гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавин ажиллаж

ажлыг хүлээлцүүлсэн. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 184 дүгээр тогтоол, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан Спортын сайдын 2018 оны А/648 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1153 дугаар захирамжийн дагуу хийгдсэн Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн Улсын тооллогыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж тайланг Улсын комисст хүргүүлсэн. Үзлэг тооллогод:

- Улаанбаатар хотын музей - 764 дэсийн 3358 ширхэг дурсгал;
- Багануур дүүргийн Соёлын ордны Орон нутаг судлах танхим – 153 дэсийн 235 ширхэг дурсгал;
- Налайх дүүргийн Соёлын ордны Орон нутаг судлах танхим – 291 дэсийн 299 ширхэг дурсгал, нийт 1208 дэсийн 3892 ширхэг дурсгалыг хамруулсан байна.

Улаанбаатар хотын музейн барилга нь түүхэн дурсгалт барилга бөгөөд музейн зориулалттай баригдаагүй бөгөөд үзмэрийн хадгалалт, хамгаалалт, үзүүллэгийн танхим стандартын шаардлага хангахааргүй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байна. Тооллогод хамрагдсан дурсгалт зүйлийн тоо дутсан, солигдсон, алдагдсан зүйл байхгүй. Улаанбаатар хотын музей, Багануур, Налайх дүүргийн Соёлын ордны орон нутаг судлах танхим байрлаж буй барилгад музейн стандартын шаардлагад нийцсэн засвар хийх, орчны чийг, дулаан хэмжилтийн багаж, үзмэр худалдан авах, үзмэрийг даатгуулах зардлыг тухайн жилийн зардалд тусгуулах шаардлагатайг дүгнэлтэд тусгасан. Нийслэлийн хэмжээнд соёлын биет ба биет бус өв, баримтат өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлан шинжлэх, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, сурталчлан таниулах зорилгоор "Соёлын өвд ээлтэй Улаанбаатар" аяныг 2017 оноос эхлэн Нийслэлийн Засаг даргын А/596 дугаар захирамжаар батлуулан хэрэгжүүлж байна.

Тус аяны хүрээнд 2019 онд :

- Улаанбаатар хотын музейн барилгыг түүхэн дурсгалт байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, өргөтгөх барилгын зураг төсөв боловсруулах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/619 дугаар захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх зураг төсөл, арга хэмжээний жагсаалтад Улаанбаатар хотын музейн түүхэн дурсгалт барилгыг сэргээн засварлах, музейн өргөтгөлийн барилгын ажлын зургийг хийлгэхэд 76.4 сая төгрөг батлуулсан. Дээрхи захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2019 оны 08 дугаар сарын 01-нд эхний нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, "Тито Архитектс" ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна.
- Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 380 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотын музейтэй хамтран "Эрт, эдүгээ, ирээдүйн Улаанбаатар" сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнг иргэд, олон нийтэд зориулж нийслэлийн дүүргүүд болон Соёлын төв өргөөнд дэлгэн үзүүлсэн.
- Нийслэл, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг 2015 оны Улсын тооллогын мэдээг түшиглэн урьдчилан боловсруулж Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтын дагуу Төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр хүлээгдэж байсан. Соёлын өвийн үндэсний төвөөс 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 251-1 тоот албан бичгээр БСШУС-ын сайдын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/365 дугаар тушаалаар батлагдсан Ажлын хэсгийн боловсруулсан маягт, зааврыг ирүүлсэний дагуу мэдээллийг эцэслэн боловсруулж нийслэл, дүүргийн хамгаалалтад байх дурсгалын саналыг хүргүүлсэн.

- Дүүргүүдийн Нийгмийн хөгжлийн хэлтэс болон Соёлын ордонтой хамтран хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тогтоол, захирамжаар батлагдсан дурсгалын хадгалалт, хамгаалалтыг хангах гэрээ, эзэмшигчтэй байгуулах гэрээг шинэчлэн хийсэн.
- Мэргэжлийн хяналтын байгууллагын 2019 оны төлөвлөгөөт шалгалтаар дүүргүүдэд хийгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтын байдалд хийсэн дүгнэлт, албан шаардлага, зөрчил арилгуулах тухай шийдвэрийг дүүргүүдийн Соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон Соёлын ордонтой хамтран илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулан тайланг МХЕГ-т хүргүүлсэн.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн “VIII Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэх тухай” зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: 2019.01.15-04.01-ний хугацаанд “Монголын сүүлчийн хаан VIII Богд Жавзандамба хутагт ба Дондогдулам хатан гэрэл зурагт” (1885-1915 он) үзэсгэлэн гаргаж, олон нийтийн хүртээл болгов. Үзэсгэлэнд VIII Богд Жавзандамба хутагтын 15-40 насны 25 зураг, Дондогдулам хатны 6 зураг дэлгэгдэн тавигдсан ба үзэсгэлэнг нийт 560 гаруй хүн үзэж сонирхов.
- Улаанбаатар хотын 380 жилийн ойд зориулан гаргасан гэрэл зургийн үзэсгэлэнгүүдийн бэлтгэл, судалгааны ажлыг 2019.10.10-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Үүнд: “Эрт-эдүгээ-ирээдүйн Улаанбаатар” гэрэл зургийн үзэсгэлэнгийн бүтэц, агуулгыг гаргаж, дэд сэдвүүдийн болон гэрэл зургийн тайлбар, гэрэл зургийн сонголтыг хийв. Мөн автобусны буудал, гудамжны мэдээллийн байгууламжид гаргах “Улаанбаатар хот - 380” гэрэл зургийн үзэсгэлэнгийн тайлбар, гэрэл зургийн сонголтыг хийсэн.

Улаанбаатар хотын нийтийн төв номын сангий үйлчилгээнд Koha програмд 38000 номын мэдээллийг хянаж, засвар, нэмэлт хийх номуудыг завсарлан RFID технологийг нэвтрүүлэн ажиллалаа.

- Коха програмд ном каталогжуулж оруулах ажлын явц 2019 оны жилийн эцсийн байдлаар Багануур дүүргийн соёлын ордны номын сан 9385 ш – 72,8%
- Багахангай дүүргийн соёлын ордны номын сан 1617 ш – 79%
- Жаргалант дүүргийн соёлын ордны номын сан 301 ш – 11.5%
- Налайх дүүргийн соёлын ордны номын сан 2299 ш – 20,9% номуудыг тус тус оруулаад байна.




Төв болон салбар номын сангийн үйлчилгээнд RFID технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай үлдэгдэл тоног төхөөрөмжийн судалгаа гарган 2019 оны 04 дүгээр сард Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт тендерийн материалыг хүргүүлсэн. http://koha.pl.ub.gov.mn -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2018 оны 12 дугаар сарын 25-аас 2019 оны 11 дүгээр сарын 28-нийг хүртэлх хугацаанд 87178 хэрэглэгч зочилж /visits/, 279314 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн

хэрэглэгчдийн 85,3% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 14,7% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.

***Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт:***

- Устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр Устах, эвдрэх, гэмтэх аюул учирч буй "Гоожингийн өндөр" хэмээх барилгын талаар Нийслэлийн Засаг даргын 2018 оны "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" А/1009 дугаар захирамж, батлагдсан удирдамжийн дагуу Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хуралдуулан өмнөх хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг үндэслэн санал, дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.
- Соёлын өвд эрсдэл учруулахуйц аливаа үйл ажиллагааг таслан зогсоож, хуульд заасны дагуу арга хэмжээ авах чиглэлээр НИТХТ-ийн 2007 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн хамгаалалтын зэрэглэлтэй "Анхны холбооны байшин"-нд Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчин үйл ажиллагаа явуулж байгаа болон өмчлөлийн маргаантай асуудалтай холбоотой мэдээлэл, холбогдох материалыг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/167 тоот албан бичгээр НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлээд байна.
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус малтлагыг таслан зогсоох, соёлын өвийн зөрчлийн талаарх мэдээллийн мөрөөр арга хэмжээ авах ажлыг удирдан зохион байгуулах чиглэлээр Нийслэлийн хэмжээнд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус малтлагын ажил 2019 оны жилийн эцсийн байдлаар бүртгэгдээгүй байна. Хөшөө дурсгалын гэмтэл, зөрчлийг хариуцсан байгууллага, гэмт буруутай этгээдээр засварлуулах ажлыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар 3 зөрчил илэрсэн.
    - Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Ариун ёс" нэртэй хөшөөг гэмтээсэнийг буруутай иргэнээр холбогдох зардлыг гаргуулан сэргээн засварлуулсан.
    - Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Ерөнхий сайд П.Гэндэнгийн байшин" буюу Хэлмэгдэгсэдийн дурсгалын музейн барилгыг зөвшөөрөлгүй нураасан.
    - Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Анхны Европ хийцийн 2 давхар барилга"-ыг зөвшөөрөлгүйгээр нураасан.

Дээрх 2 барилгын асуудлаар Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам болон хууль бусаар нураасан байгууллага, хуулийн этгээдэд зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах тухай албан бичиг хүргүүлсэн.

*Тус газрын харьяа Улаанбаатар хотын музейн үйл ажиллагааны хүрээнд:*

- Улаанбаатар хотын музейгээс байгууллага, иргэдийн гар дээр буй эд өлгийн зүйлсийн хайгуул, судалгааг тогтмол явуулж байгаа бөгөөд 2019 онд музейн сан хөмрөгт 2 дэсийн 26 ширхэг үзмэрээр сан хөмрөгөө баяжуулав.
- Сан хөмрөгийн өрөө болон үзүүллэгийн танхимын чийг дулааны байдалд долоо хоног бүр хяналт тавин бүртгэл хөтөлж байна. Сан хөмрөгийн өрөөнд хуваарийн дагуу долоо хоногт нэг удаа тогтмол цэвэрлэгээ хийж байна. Мөн үзүүллэг дэх үзмэрийн цэвэрлэгээ хийх хуваарийг батлуулж, хуваарийн дагуу 4 удаагийн цэвэрлэгээг хийгээд байна.
- Үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Уран зургийн төрлийн 3 дэсийн 3 ширхэг 150х100 дээш хэмжээтэй 3 уран зургийг тоос шорооноос хамгаалсан баглаа боодол, UBM 58.6, UBM 58.5, UBM 58.4 үзмэрүүдэд

хамгаалалтын уут хийж хадгалалтын нөхцөлийг дээшлүүлсэн. Музейн үзүүлэгийн танхим дахь "Их хүрээний судалбар" UBM67.4-1, UBM67.4-2, UBM67.4-3, UBM67.4-4, UBM67.4-6, Анхны сургууль UBM 61.161 хувийн дугаартай уран зураг, үзмэрийн жаазыг засаж сан хөмрөгийн 420 дэсийн 510 ширхэг үзмэрийг катлогижуулах ажил бүрэн дуусаж, үзмэрүүдийн каталогийг баяжуулах ажлыг хийж байна.

- Сан хөмрөгийн гэрэл зургийн төрлийн 40 дэсийн 468 ширхэг, баримт бичгийн төрлийн 21 дэсийн 21 ширхэг, бэлэг дурсгалын 2 дэсийн 2 ширхэг үзмэр, нийт 63 дэсийн 491 ширхэг үзмэрт хувийн дугаар тавьсан.
- Үзүүллэг, үзмэрийн тайлбар, мэдээллийг үзүүллэгийн танхимын дэлгэцээр болон музейн цахим сайтуудаар үзэгчдэд тогтмол хүргэж, үзүүллэгт шинээр дэглэгдсэн 13 үзмэр, "Социалист Улаанбаатар" үзэсгэлэнд дэглэгдсэн 35 үзмэрт шинээр хаяг тайлбар боловсруулан байршуулав.
- Тайлант хугацаанд үзмэрийн дэлгэрэнгүй тайлбар хийх ажлын хүрээнд үзмэрийн жагсаалтыг боловсруулан батлуулж, жагсаалтын дагуу үзмэрийн судалгаа хийж, 10 үзмэрт дэлгэрэнгүй тайлбарыг боловсруулж, тайлбарт хавтсыг баяжуулсан бөгөөд оюутан судлаач, үзэгчдэд дэлгэрэнгүй тайлбарыг ашиглуулж эхэлсэн.

*Хүүхэд, залуус, иргэдэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах, нийслэл хотоороо бахархах үзэл санааг төлөвшүүлэх чиглэлээр* Хүүхэд, залуус, иргэдэд соён гэгээрүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалах, сурталчлах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулан ажиллав. Үүнд:

Олон Улсын музейн өдрийг тохиолдуулан Улаанбаатар хотын түүх, соёл болон соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх, Улаанбаатар хоытн музейн үйл ажиллагааг сурталчлан таниулах "Улаанбаатар хотын нээлттэй өдөр" арга хэмжээг 2018 оны 05 дугаар 18-ны өдөр зохион байгуулав. Нээлттэй өдөр арга хэмжээний хүрээнд:

- "Социалист Улаанбаатар" сан хөмрөгийн сэдэвчилсэн үзэсгэлэн;
- Музейн гадна талбайд "Улаанбаатар хот гэрэл зурагт 1874-2014 он" үзэсгэлэн;
- Музейн гадна талбайд "Хүрээ гоёл" гэрэл зургийн үзэсгэлэн, Монгол-Америк хүүхдүүдийн зургийн хэцний үзэсгэлэн;
- Хүүхэд, гэр бүлд зориулсан "Би хотын иргэн" боловсролын ажил;
- "Түүхээр аялсан агшин" хэмээх гэрэл зургийн булан ажиллуулж, Өндөр Гонгортой хамт болон Социализмын үеийн дурсамжтай хамт гэрэл зургаа авахуулах үйлчилгээ;
- Улаанбаатар хотын уран бичлэгийн үзүүлбэр болон бичүүлж авах үйлчилгээ;
- Эбру урлаг буюу усан дээр зураг зурах үзүүлбэр ба зурж үзэх үйлчилгээ;
- Ахмад настнуудаас "Улаанбаатар хотын дурсамж бичүүлж авах" зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2019.05.25-ны өдөр зохион байгуулсан "Чингэлтэй фестиваль"-д оролцож, Улаанбаатар хот гэрэл зурагт явуулын үзэсгэлэн, Хэцний үзэсгэлэн гаргаж, хүүхэд, залууст Усан дээр зураг зурах үйлчилгээгээр үйлчилж, монгол гэрт социалист Улаанбаатар хотын айл ямар байсантай танилцаж, гэрэл зургаа авахуулах боломжийг бүрдүүлэн ажиллав. Энэ өдөр нийт 1800 хүнд үйлчлэв.

Монголын сүүлчийн хаан VIII Богд Жавзандамбын мэндэлсний 150 жилийн ойд зориулан 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр "Богд хаан ба Улаанбаатар: 1885-1926" гэрэл зургийн үзэсгэлэнг музейн үзэсгэлэнгийн танхимд дэглэн гаргав. Энэ үзэсгэлэн 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл үргэлжлэн гарсан. Нийт 254 хүн үзсэн. Улаанбаатар хотын 380 жилийн ойг тохиолдуулан хотын түүх, соёлыг сурталчлах зорилгоор Хүннү Эйр ХХК-тай "Хамтран ажиллах гэрээ" байгуулав. Энэхүү гэрээний дагуу Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Дорнод, Өмнөговь аймгийн төвүүдэд "Улаанбаатар хот гэрэл зурагт"

явуулын үзэсгэлэнг гаргаж, нийт 3700 гаруй хүнд хотын түүхэн хөгжлийг гэрэл зургаар таниулав.

Номын соёлт ертөнц ТББ-аас 2019 оны 05 дугаар сарын 23-аас 25-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан "Ulaanbaatar book fair" номын баярт оролцож, Улаанбаатар хотын түүхийн холбогдолтой ном, сэтгүүл, каталоги, бэлэг дурсгалын дурсгалын зүйлс худалдаалж, Өнөөдрийн Улаанбаатар сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн гаргав.



Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан Чингэлтэй фестивальд оролцож, Улаанбаатар хот гэрэл зурагт явуулын үзэсгэлэн гаргав. Энэхүү үзэсгэлэнг 1100 хүн үзэж сонирхсон.



Соёл, урлагийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт 2019 оны 06 дугаар сарын 16-ны өдөр оролцож, байгууллагын үйл ажиллагаа болон Улаанбаатар хотын түүхийг сурталчлав. Асарын гадна талбайд "Улаанбаатар хот гэрэл зурагт 1874-2014 он" гэрэл зургийн явуулын үзэсгэлэн, асар дотор "Өнөөдрийн Улаанбаатар" гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж, мөн монголын хамгийн өндөр хүн "Өндөр Гонгор"-ын 1922 онд авхуулсан гэрэл зургийг түүний биеийн хэмжээгээр хэвлэж олон нийтэд таниулах, гэрэл зураг хамт авахуулах боломжийг бүрдүүлэв. Улаанбаатар хотын түүхийн холбогдолтой ном, хэвлэлийг дэлгэн тавьж олон нийтэд танилцуулав. Энэ өдөр музейн үзэсгэлэнг 4100 гаруй хүн үзэж сонирхов.

***<u>Үндэсний соёл урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг өргөжүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах зорилтын хүрээнд;</u>***

Нийслэлийн Соёл, урлагийн газраас соёл, урлагийн гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, үндэсний соёл урлагаа дэлхий нийтэд таниулах соёлын солилцоог өргөжүүлэх зорилгоор байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд жил бүр тодорхой ажлуудыг тусган хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд хоёр хотын дүрслэх урлагийн салбарын уран бүтээлчдийн хамтарсан "Эгч дүүс хотуудын уран бүтээлчдийн хамтарсан үзэсгэлэн"-г "Монголын урчуудын эвлэлийн хороо"-ны дэргэдэх Залуу уран бүтээлчдийн нэгдэлтэй хамтран зохион байгуулах юм.

### ***<u>1.3. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын чиглэлээр:</u>***

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт соёл, урлагийн чиглэлээр тусгагдсан заалтуудын хэрэгжилт 2019 оны жилийн эцийн байдлаар 100%-тай, НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст тайлагнасан.

## 1.4. Улс болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт:

Нийслэлийн Соёл, урлагийн салбарт Улаанбааатар хотын төв номын санд орчин үеийн аюулгүй байдал, цахим номын сан, хэрэглэгчдэд богино хугацаанд хүртээмжтэй RFID технологийг бүрэн нэвтрүүлж дуусгахад 2019 оны нийслэлийн төсөвт 330 сая төгрөг тусгагдсан. Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын "Худалдан авах ажиллагаа хэрэгжүүлэх тухай" 2019 оны А/735 дугаар захирамжаар Улаанбаатар хотын төв номын сан болон Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт захиалагчийн хяналт тавих эрх олгогдсон. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас “IT zone” ХХК шалгарч 2019 оны 12 дугаар 09-нд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлж дууссан. Салбар номын сангийн засварын ажлыг гүйцэтгэхэд нийслэлийн төсөвт 170 сая төгрөг батлагдсан. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/735 дугаар захирамжаар Улаанбаатар хотын төв номын сан болон Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт захиалагчийн хяналт тавих эрх олгогдож Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас “Цагаан удам” ХХК-ыг шалгаруулан 2019 онд дотор засварын ажил, 2020 онд гадна засварын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн.



Сонгинохайрхан болон Багануур дүүргийн 850 хүний суудал бүхий Соёлын ордны барилгын ажилд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас ажил тус бүрд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан төлөвлөгөөний дагуу газар шорооны ажил 100 хувь дууссан.

## 1.5. Бүсчилсэн хөгжлийн бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд:

***Тэргүүлэх зорилт 1.*** *Соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр* Улаанбаатар хотын музейн барилгыг түүхэн дурсгалт байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, өргөтгөх барилгын зураг төсөв хийлгэх ажилд Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/619 дүгээр “Эрх шилжүүлэх тухай” захирамжаар 76.4 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн бөгөөд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт сонгон шалгаруулалт зарлан ажиллаж байна. **Гүйцэтгэл 70 %**

- Хан-Уул дүүргийн Соёлын ордны бага танхимыг номын уншлагын жишиг танхим хэлбэрээр тохижуулах: Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/427 дугаар захирамжийн дагуу Хан-Уул дүүргийн Соёлын ордны бага танхимыг номын уншлагын жишиг танхим хэлбэрээр тохижуулсан. **Гүйцэтгэл 100 %**
- Нийслэлийн Засаг даргын "Худалдан авах ажиллагаа хэрэгжүүлэх тухай" 2019 оны А/735 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан нээлттэй сонгон шалгаруулалтад “IT zone” ХХК шалгарч нийлүүлэлт, угсралтын ажил хийгдэж дууссан. **Гүйцэтгэл 100%**
- Зорилтын хүрээнд тухайн жилд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын холбоотой ажлуудын захирамж, шийдвэрүүд гарсан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу явагдаж байна. **Хэрэгжсэн хувь- 70%**

***Тэргүүлэх зорилт 2.*** *Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгуулан ажиллаж байна. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн Улсын тооллогыг зохион байгуулах;*

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 184 дүгээр тогтоол, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан Спортын сайдын 2018 оны А/648 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1153 дугаар захирамжийн дагуу хийж Улсын комисст хүргүүлсэн. **Гүйцэтгэл -100 %**
- Зорилтын хүрээнд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16.1.5, 26.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоол, БСШУС-ын сайдын 2018 оны А/648 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1153 дугаар захирамжийн дагуу Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн Улсын тооллого хийгдсэнээр музейн сан хөмрөгийн бүртгэл судалгаа шинэчлэгдэн цаашид авах арга хэмжээний санал боловсруулагдаж байна. **Хэрэгжсэн хувь -100%**

### ***1.6. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд Нийслэлийн Засаг даргын хооронд 2019 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний соёл, урлагийн чиглэлээрх заалтын хэрэгжилт***

Засгийн газрын чиг үүргийг нийслэлд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд соёл, урлагийн салбарт Гандантэгчинлэн хийдийн өргөтгөл, Үндэсний номын сангийн шинэ байр, Сонгинохайрхан дүүрэгт шинээр соёлын ордон байгуулах ажлууд тусгагдсан бөгөөд 2020 оны 03 дугаар сард гэрээний хэрэгжилтийг гарган НЗДТГ болон БСШУСЯ-д тус тус хүргүүлнэ.

### ***1.7. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:***

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт соёл, урлагийн чиглэлээр хэрэгжүүлэх 7 үндсэн заалт тусгагдсан бөгөөд хэрэгжилтийг хангах арга хэмжээг Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх жил бүрийн зорилтод үе шаттайгаар тусган хэрэгжүүлж ажиллаж байна. Хэрэгжилтийн нийт хувь 2019 оны жилийн эцсийн байдлаар **100%-тай** байна.

***Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт:***

***"Чулуун соёлын өв"*** үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт - Хадны бичиг үсгийн дурсгал – 3 дэсийн 3 дурсгал; - Булш оршуулгын дурсгал – 60 дэсийн 297 дурсгал; - Тахил, тайлгын байгууламж – 5 дэсийн 8 дурсгал тус тус бүртгэгдсэн байна. Эдгээрээс 2 хадны бичиг үсгийн дурсгал нь Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор эрх зүйн хамгаалалтад орсон байдаг. Бусад дурсгалыг 2015 оны Улсын тооллогод хамруулан бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн бөгөөд нийслэл, дүүргийн хамгаалалтад авах санал боловсруулсан. Улаанбаатар хотын музейтэй хамтран "Хотын аялал"-ын маршрутад Их тэнгэрийн амны хадны зургийг оруулан ЕБС-ын сурагчид, оюутан залуучууд, төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг хамруулсан. Нийт 8 удаагийн аялалд 300 гаруй хүн оролцсон. Чулуун соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчилхад зориулагдсан төсөв байдаггүй нь Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна. Мөн чулуун соёлын өв бүхий газарт иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгож буй газар олголт эрсдэл учруулж байна.

***"Соёлын баримтат өв"*** үндэсний хөтөлбөрийн "Соёлын баримтат өвийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх" заалтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.2-т "Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үйлчилгээг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн цахим хэлбэрт шилжүүлж, алслагдсан дүүргийн Соёлын ордны номын сангийн хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ" гэсэн заалтыг тусгуулан ажиллаж байна. Уг заалтыг хэрэгжүүлэхээр Багахангай, Багануур, Налайх, Сонгинохайрхан дүүргийн Жаргалантын Соёлын ордны номын сангийн үйл ажиллагааг КОХА сүлжээнд бүрэн холбосон. Улаанбаатар хотын төв номын санд орчин үеийн аюулгүй байдал, цахим номын сан, хэрэглэгчдэд богино хугацаанд хүртээмжтэй RFID технологийг бүрэн нэвтрүүлж дуусгахад 2019 оны нийслэлийн төсөвт 330 сая төгрөг тусгагдсан. Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын "Худалдан авах ажиллагаа хэрэгжүүлэх тухай" 2019 оны А/735 дугаар захирамжаар Улаанбаатар хотын төв номын сан болон Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт захиалагчийн хяналт тавих эрх олгогдсон. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас IT zone ХХК шалгарч 2019 оны 12 дугаар сарын 09-нд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлж олон улсын стандарт, шаардлагад нийцсэн RFID төхөөрөмжийг нэвтрүүлсэн.

"Соёлын баримтат өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах" заалтын хүрээнд Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн салбар номын сангийн барилгын орчин нөхцөлийг сайжруулахаар 2019 оны нийслэлийн төсөвт 170 сая төгрөг батлагдсан. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/735 дугаар захирамжаар Улаанбаатар хотын төв номын сан болон Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт захиалагчийн хяналт тавих эрх олгогдож Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас "Цагаан удам" ХХК-ыг шалгаруулан 2019 онд дотор засварын ажил, 2020 онд гадна засварын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөнөөр Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн төв салбарын барилгын орчин нөхцөл сайжирсан.

"Соёлын баримтат өвийг сэргээн засварлах" заалтын хүрээнд УБХНТНСанд урагдаж гэмтсэн нийт 43 ш ном хэвлэлийг хэвлэлтийн анхны хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан. Улаанбаатар хотын музей нь Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх, сэргээн засварлах журмын дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд дараах ажлыг тусгасан.

- 2019 онд сэргээн засварлалтад явуулсан үзмэрийн тайланг архивлах
- Сан хөмрөгчийн ажил хүлээлцсэн актыг архивлах
- 2018 оны сан хөмрөгийн улсын тооллогын тайлан архивлах
- "Нийслэл гайд" сэтгүүлийг бүртгэл мэдээллийн санд авах зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулан ажилласан.

"Соёлын баримтат өвийг судалгааны эргэлтэд оруулах, сурталчлах" заалтын хүрээнд Нэг уншигч - нэг номын сан" үйлчилгээний зорилтыг хэрэгжүүлэн, Багануур, Багахангай, Налайх, Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордны номын сангуудыг Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн КОХА сүлжээнд холбож, уншигч, үйлчлүүлэгчдэд төв болон салбар номын сангуудаар ижил үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэн ажилласан. Нийслэлийн Соёл, урлагийн салбарын тайлант өдөрлөг үйл ажиллагааг 2019 оны 11 дүгээр сард тус газрын харьяа байгууллагуудад зохион байгуулж, нийт 8 байгууллагад 11 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 5000 гаруй иргэд хамрагдаж, номын сангийн үйлчилгээ болон "Эрт эдүгээ ирээдүйн Улаанбаатар" явуулын үзэсгэлэнг зохион байгуулав.

Тайлант хугацаанд соёлын баримтат өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн барилгын засварын ажлыг эхлүүлж, номын сангийн үйлчилгээнд олон улсын стандарт шаардлагад нийцсэн RFID технологи нэвтрүүлэхэд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 500 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлүүлсэн бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал үр дүн үзүүлсэн.

***"Сонгодог урлаг -3"*** үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 241 дугаар тогтоолын дагуу 2020-2023 онд Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн төслийг 3 зорилтын хүрээнд 6 үйл ажиллагааг нийт 4 жилийн хугацаанд 1 602 000 000 төгрөгний төсвийн төсөөлөлтэй боловсруулж байна. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу БСШУСЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Сүхбаатар дүүргийн Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Монголын Урлагийн зөвлөл, Төгөлдөр Урлаг ТББ-аас санал авахаар хүргүүлээд байна. Тус дэд хөтөлбөрийг 2020 оны 1 дүгээр сард НЗД-ын зөвлөлийн хурлаар оруулна. Тус хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/684 дугаар захирамжийн дагуу 109 130 000 сая төгрөгний санхүүжилтээр Сонгодог урлагийн "Гала" фестиваль зохион байгуулан ажилласан.

***"Соёлын үйлдвэрлэл"*** дэд хөтөлбөрийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 53 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2018-2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 4 зорилт 11 чиглэлээр боловсруулан Нийслэлийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/485 тоот захирамжаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Соёлын үйлдвэрлэл эрхэлж буй иргэн хуулийн этгээдийн судалгаа боловсруулан нийслэлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бий болгосон.
- Нийслэлийн Соёл, урлагийн байгууллагын хөрвөх чадварыг нэмэгдүүлж, соёлын үйлдвэрлэлийг кластерын зарчмаар хөгжүүлэх төсөл боловсруулах судалгааны ажлыг "Бүтээлч үйлдвэрлэл инновацийн төв" ТББ-тай хамтран хийсэн. Судалгааны ажлын хүрээнд соёлын бодлого, эрх зүйн орчны шинжилгээ, нийслэлийн хүн амын сэтгэл ханамжийн судалгаа, соёл, чөлөөт цагийн зах зээлийн төлөв байдлын судалгаа, соёлын ордны менежментийн чадавхын болон соёлын ордны үйлчилгээний чанарын үнэлгээ, соёлын ордны орчин нөхцөлийн үнэлгээ гэсэн цогц байдлаар шинжилгээ, үнэлгээг олон улсын аргачлалаар хийлгэсэн. Энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан Соёлын ордонуудыг XXI зууны хөгжлийн хандлага, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх стратегийн хувилбар, бодлогын зөвлөмж боловсруулагдах юм. Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар түүний нөлөөг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг нийслэлийн хэмжээнд өрнүүлэхэд оршиж байгаа юм.

"Соёлын үйлдвэрлэл" дэд хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, нийслэлийн Засаг даргын орлогчоор батлуулан ажиллаж байна.

Хөтөлбөрийг анхан дунд шатанд хэрэгжүүлэх хүний нөөцийг чадавхжуулах сургалтуудыг эхлүүлж, 9 дүүргийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, дүүргүүдийн соёлын ордны захирал, менежерүүдэд 2 удаагийн сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, БСШУСЯ, СУИС-иас Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр зохион байгуулсан олон улсын зөвлөгөөнд оролцуулж, чиг хандлага, туршлагаас танилцуулсан.

Оюуны өмчийг дээдлэгч хот аян өрнүүлж зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг сурталчлах видео контентуудыг бэлтгэж байна. Мөн соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор судалгааны маягтыг боловсруулан, судалгаа хийх аргачлалын талаар 9 дүүргийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан.

Мөн тус газрын харьяа Улаанбаатар хотын нийтийн төв номын санд хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, бусдаас суралцах арга барилыг эзэмшүүлэх зорилгоор Зохиолч Луужир Жиймийгийн "Намайг өөрчилсөн 85 эмэгтэй" номын хэлэлцүүлэг, уулзалтыг зохион явууллаа. Уулзалтад 24 уншигч, бүсгүйчүүд хамрагдлаа.




Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г. Очбаяр бяцхан уншигч, нийслэлчүүддээ Улаанбаатар хотын түүх, соёлын талаар "Бид ямар хотод аж төрөн амьдардаг вэ?" сэдвийн хүрээнд лекц уншуулж, харилцан яриа хийлээ. Уулзалтад 31 дүгээр сургуулийн 30 гаруй сурагч хамрагдлаа.

Нийслэлийн 380 жилийн ойг угтаж "Хотын соёл-Номноос эхлэнэ" уулзалтыг Хүүхдийн зохиолч О.Сундуйтай БЗД-ын Гачуурт тосгоны 85 дугаар сургуулийн 5б ангийн Н.Сувдаа багштай ангийн сурагчдын дунд номын санч Д.Дэлгэрсайхан, ном зүйч О.Долгорсүрэн нартай хамтран зохион байгуулж ажилласан. Уг арга хэмжээнд нийт 135 сурагчид хамрагдсан.



### *1.1. <u>Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт:</u>*

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд соёл, урлагийн чиглэлээр нийт 7 ажил төлөвлөгдсөн бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт ийн гүйцэтгэлтэй байна.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## ***2.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүн***

| | | | Нийт | УИХ-ын БХ-ны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэмдэглэл | Засгийн газрын тогтоол | Ерөний сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан даалгавар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт шийдвэрийн тоо | | | 10 | | 2 | | | 4 | | 3 | 1 |
| Нийт заалтын тоо | | | 41 | | 3 | | | 14 | | 23 | 1 |
| Бүрэн хэрэгжсэн | | 100 | 37 | | 3 | | | 14 | | 19 | 1 |
| Хэрэгжиж байгаа | | 70 | 4 | | - | | | - | | 4 | - |
| Эрчимжүүлэх шаардлагатай | | 30 | - | | - | | | - | | - | - |
| Хэрэгжээгүй | | 0 | - | | - | | | - | | - | - |
| | Зохион байгуулалтаас шалтгаалсан | | - | | - | | | - | | - | - |
| | Хөрөнгө дутагдсанаас шалтгаалсан | | | | | | | | | | |
| Хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй | | | - | | - | | | - | | - | - |
| **Гүйцэтгэлийн хувь** | | | 97% | | 100% | | | 100% | | 94.7% | 100% |
| **Үнэлгээний хувь** | | | 100% | | 100% | | | 100% | | 100% | 100% |

## ***2.2 НИТХ-ын тогтоолын хэрэгжилт :***

Байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу улирал, хагас, бүтэн жилийн байдлаар тайлагнан ажиллаж байна. НИТХ-ын 2016 оны "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 35 дугаар тогтоолын дагуу соёл, урлагийн сургалт, цэнгээнт үйлчилгээ эрхлэгчдэд зөвшөөрөл олгох ажлыг тус газар хэрэгжүүлэн ажиллаж байна. Зөвшөөрөл авахыг хүссэн иргэд, аж ахуйн нэгжийн хүсэлтийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр хүлээн авч хүнд суртал, чирэгдэлгүйгээр үйлчилж байна. НИТХ-ийн 2016 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан "Соёл



урлагийн сургалт, цэнгээнт үйлчилгээний журам"-ын дагуу Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төвөөр дамжуулан аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг хугацаанд нь хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж ажиллаж байна. Тус газарт 2019 оны байдлаар нийт 335 аж ахуйн нэгж байгууллагуудаас хүсэлт ирснээс гэрчилгээ олгосон 289, буцаагдсан 38 байна. Мөн "Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөрийг нийслэлд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.

## 2.3 *Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт:*

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг 2019 оны жилийн байдлаар нийт 10 захирамжлалын баримт бичиг ирсэн бөгөөд тайлант хугацаанд багтаан гүйцэтгэлийг цаасаар болон lmonitoring.ub@gov.mn цахим сайтад оруулан тайлагнаж ажилласан. Үүнд:

- Зарлиг – 2
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл –3
- Засгийн газрын тогтоол -4
- Засгийн газрын албан даалгавар - 1

**МУ-ын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны хуралдааны 3 дугаар тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгавар:**

МУ-ын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны хуралдааны 3 дугаар тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгаврын 9 заалтын дагуу төлөвлөгөө боловсруулан батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна. Хагас, бүтэн жилийн байдлаар НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

2019 онд хэрэгжүүлэх "Иргэдийн оролцоотой хөгжлийн жил"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд соёл, урлагийн чиглэлээр тусгагдсан ажлын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулах:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамжаар батлагдсан 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр "Иргэдийн оролцоотой хөгжлийн жил"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд соёл, урлагийн чиглэлээр тусгагдсан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 заалт 3 хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан. Тус төлөвлөгөөнд "Соёлтой үйлчилгээ" болзолт уралдааныг нийслэлийн хэмжээнд зохион байгуулахаар 2 удаа захирамжийн төсөлд санал авсан боловч, удирдлагын зүгээс хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзсэн тул үнэлэх боломжгүй болно.

**Нийслэлийн Засаг даргын хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжид өгсөн үүрэг даалгавар:**

Нийслэлийн Засаг даргын хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжид өгсөн үүрэг даалгаврыг хэрэгүүлэх ажлын төлөвлөгөөг 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдөр 3 заалтын дагуу төлөвлөгөө боловсруулсан баталсан. Тус газраас 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдөр НЗДТГ-т биелэлтийг хүргүүлсэн. Зөвлөмжийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Тус газар нь “Никвишн” ХХК-наас хуруу уншигч төхөөрөмж худалдан авсан бөгөөд ажлын цагийн бүртгэлийн системд газрын дарга болон нэгжийн дарга 2, 10 ажилтан нийт 13 ажилтан, албан хаагчдыг уг төхөөрөмжид хурууны хээг таниулан, бүрэн бүртгэлжүүлж, гадуур ажлын дэвтэр хөтлөн цаг ашиглалтад хяналт тавьж, өвчтэй чөлөөтэй албан хаагчдыг чөлөөний хуудас болон эмнэлэгийн магадлагааг үндэслэн цалин бодолттой холбож хариуцлага тооцон ажиллаж байна.

***Нийслэлийн удирдлагаас цаг үеийн ажил төрлийн асуудлаар өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт:***



Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/334 дугаарын захирамжаар батлагдсан “Нийслэлийн албан байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн зохион байгуулах журам”-ын дагуу батлагдсан хуваарийн дагуу газрын дарга тогтмол оролцож байна. Нийслэлийн удирдлагаас цаг үеийн шинжтэй өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг “Шуурхай зөвлөгөөн зохион байгуулах журам”-ын дагуу хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн удирдах албан тушаалтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 14 хоног тутамд www.ulaanbaatar.mn цахим сайтад хэрэгжилтийг оруулан тайлагнаж ажилласан.



Мөн Нийслэлийн Соёл, урлагийн газрын харьяа байгууллагуудын удирдах ажилтнууд болон дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ээлжит шуурхай хурлыг 2 сар тутам зохион байгуулж, хийж, хэрэгжүүлсэн ажлууд болон цаашид шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудын тухай танилцуулсан.



2019 оны хувьд Нийслэлийн Соёл, урлагийн газраас их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн их засвар, номын сангийн үйлчилгээний RFID технологийн хөрөнгө оруулалт, Улаанбаатар хотын музейн барилгыг сэргээн засварлах зураг төсөв, Соёлын төв өргөөний барилгын дээврийн их засвар болон хөгжим техникийг шинэчлэх ажил, Багануур, Сонгинохайрхан дүүргүүд дэх Соёлын ордны шинэ барилгын ажил, Чингэлтэй дүүргийн Соёлын ордны газрыг шийдвэрлэн ажиллаж байгаагийн зэрэгцээ “Соёлын үйлдвэрлэл”, “Соёлын өвд ээлтэй Улаанбаатар” зэрэг дэд хөтөлбөр, “Хотын соёл”, “Оюуны өмчийг дээдл эгч Улаанбаатар хот” зэрэг аяныг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар газрын дарга болон холбогдох албан тушаалтнууд танилцуулсан.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### 3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт:

*Нийслэлийн Соёл, урлагийн салбарын статистикийн мэдээг нэгтгэж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүлэх;*

Нийслэлийн Соёл, урлагийн салбарын 2018 оны албан ёсны статистикийн мэдээллийг төрийн 13 байгууллага, хувийн хэвшлийн 10 байгууллагыг хамруулан Үндэсний Статистикийн Газрын даргын 2003 оны 114 дүгээр тушаалаар батлагдсан төвлөрсөн мэдээллийн 7 маягт, БСШУСЯ-ны сайдын 221 дугаар тушаалаар батлагдсан төвлөрсөн бус мэдээллийн 9 маягтын дагуу графикт хугацаанд нэгтгэн боловсруулж Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүлсэн. Үүнд:

**Соёл, урлагийн салбарын байгууллагуудын үзэгч, үйлчлүүлэгчид /мянган.хүн/**

| Байгууллагын төрөл | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|
| Мэргэжлийн урлагийн байгууллага | 827.2 | 1 477.9 | 1 054.4 |
| Музей | 219.7 | 237.8 | 371.8 |
| Номын сан | 186.4 | 158.3 | 223.1 |
| Соёлын төв | 1338.9 | 975.7 | 715.5 |
| Кино үзвэрийн байгууллага | 1040.1 | 1175.1 | 4404.9 |

**Соёл, урлагийн салбарын байгууллагын тоо**

| Байгууллагын төрөл | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|
| Мэргэжлийн урлагийн байгууллага | 11 | 11 | 11 |
| Музей | 5 | 5 | 21 |
| Номын сан | 10 | 10 | 10 |
| Соёлын төв | 13 | 13 | 14 |
| Кино үзвэрийн байгууллага | 6 | 8 | 28 |

*Улаанбаатар хотын нийтийн төв номын сан:* Салбар номын сангийн хэмжээнд 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар бүтээгдэхүүн нийлүүлэлтийг үзүүлбэл:




| | Бүртгэлтэй уншигч | Ирц | Ном олголт | НИЙТ |
|---|---|---|---|---|
| Төлөвлөгөө | 19300 | 119700 | 299250 | 438250 |
| Биелэлт | 13333 | 93882 | 207168 | 314383 |




2019 оны уншигчийн төлөвлөгөө **69,8%**-ийн биелэлттэй байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийн биелэлттэй харьцуулахад **1016**-аар буюу **4,5%**-иар буурсан байна. Гэрээр ном олголт уншигч хэрэглэгчдэд **207168** ном хэвлэл олгож үйлчилснээс 14,2% буюу **29540** ширхэг номыг гэрээр олгож үйлчилсэн байна.







*<u>Байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг цахим хуудсаар тогтмол мэдээлж ажиллах;</u>*

Тус газрын http://nsug.ub.gov.mn цахим хуудсаар хэрэгжүүлсэн ажил, мэдээ мэдээллийг цаг тухайд нь нээлттэй мэдээлж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан. Цахим мэдээ мэдээллийн нээлттэй байдал, хүртээмжийн талаар улирал тутам санал асуулга явуулж байна. Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийн баазыг www.ub1234.mn сайт, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн сангийн http://www.ublegal.mn/ вэб сайт, шилэн дансны http://www.ublegal.mn/ сайтад тогтмол байршуулж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын http://nsug.ub.gov.mn вэб сайтын мэдээллийн санд тогтмол байршуулж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын цахим хуудсанд давхардсан тоогоор 590869 зочин зочилж, Facebook хуудсанд 11819 дагагчтай, үйл ажиллагааны мэдээг тухай бүр түгээснээс гадна байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь шинэчлэн вэб сайтын мэдээллийн санд тогтмол

байршуулж, нийтэд хүргэж байна. Тайлант хугацаанд газрын даргын А тушаал 59, Б тушаал 33 гарсныг цахим хуудсанд 100% байршуулсан.

*Байгууллагын үйл ажиллагааны талаар хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч үйл ажиллагаандаа тусгаж ажиллах;*

Нийслэлийн нээлттэй хаалганы өдөр арга хэмжээ, "Номоо солилцъё" өдөрлөг, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн үйл ажиллагаанууд болон бусад үйл ажиллагаанууд дээр иргэдийн дунд сэтгэл ханамжийн судалгаа явуулсан бөгөөд нийт 1810 иргэн оролцож 1539 иргэн буюу **85%** нь сэтгэл ханамжтай гэсэн судалгааны дүн гарсан.

**Байгууллагын сэтгэл ханамжийн судалгаа**




*Өмч эзэмшлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах;*

Газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/10 тоот тушаалаар байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг шинэчлэн байгуулж, 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу байгууллагын хөрөнгийн эхний хагас жилийн тооллогыг хийсэн. Мөн тус газрын хөрөнгөд бүртгэлтэй “Цөмөөхэй балет” бүжгэн жүжгийн хувцас хэрэглэлийг Дуурь Бүжгийн Эрдмийн театрт балансаас балансад шилжүүлэх тухай шийдвэр гарган тооллогын ажлыг хийж дууссан. Тус газрын өмч хамгаалах комиссын 2019 оны жилийн эцсийн байдлаар хийсэн ажлын хэрэгжилтийн тайланг гаргаж Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын байгуулсан өмч эзэмшлийн гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэн ажиллаж байна. Өмч хамгаалах комисс нь 2019 оны хагас жилд 6 удаа хуралдаж элэгдлийн хугацаа дуусаж цаашид ашиглагдах боломжгүй болсон 32 нэр төрлийн 30 гаруй сая төгрөгийн бараа материал акталж, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2019 оны А/31 дугаар тушаалын дагуу Сонгинохайрхан дүүргийн Соёлын ордон, Багануур дүүргийн Соёлын ордон, Налайх дүүргийн Соёлын орднуудад шаардлагатай хөрөнгүүдийг балансаас балансад шилжүүлсэн, Тус газрын ашиглаж байсан автомашиныг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт хүсэлт гарган Нийслэлийн Засаг даргын захирамж гаргуулан дуудлага худалдаагаар худалдагдаалагдсны дараагаар байгууллагын данс бүртгэлээс хасахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Мөн Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2019 оны А/30 дугаар тушаалын дагуу тус газарт шаардлагатай байсан 4 ширээг Улаанбаатар чуулгаас балансаас балансад шилжүүлэн авсан. Тус газрын Өмч хамгаалах комисс нь үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн хийх бүрд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газартай байгуулсан гэрээний дагуу тухайн газарт хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн болно. Тус газар нь 2019 оны 6 дугаар сард багтаан хагас жилийн эд хөрөнгийн тооллого явуулсан

ба 12 дугаар сард багтаан бүтэн жилийн тооллого явуулахаар бэлтгэл ажил ханган ажиллаж байна.

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;*




Шилэн дансны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 384 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу мэргэжилтэн, нягтлан бодогч нар өөрийн хариуцсан мэдээллийг цаг хугацаанд нь байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд оруулаагүй мэдээлэл байхгүй болно. Тайлант хугацаанд тус газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2019 оны төсвийн төлөвлөгөө, 2019 төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэгдэж, тайланг журмын дагуу тус тус байгууллагын цахим хуудас, www.shilendans.gov.mn сайт, шилэн дансны самбарт байршуулж олон нийтэд мэдээллийг хүргэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Монгол Улсын "Шилэн дансны тухай" хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох" журамд заасны дагуу тайлант хугацаанд багтаан www.shilendans.gov.mn вэб сайт болон байгууллагын шилэн дансны самбарт байрлуулж олон нийтэд мэдээллийг хүргэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан.Тус газар болон түүний харьяа байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын тайлан мэдээг авч, төсвийн шууд захирагчид танилцуулан, мэдээллийн самбар болон цахим хуудсанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллагад чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. Мөн "Нийслэлийн Засаг даргын 2012 оны Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 606 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

*Авлигын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;*

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн https://meduuleg.iaac.mn цахим системд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу 2019 оны 2 дугаар сард байгууллагаас нийт 4 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ мэдүүлж, баталгаажуулсан бөгөөд хугацаанд нь **100%**-тай мэдүүлж ажилласан.

Тус газарт ахлах мэргэжилтний албан тушаалд шинээр томилогдсон 1 албан хаагч Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг хүлээн авч дүгнэлтийг үндэслэн 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр томилсон. Мөн Хасхомыг 30 хоногийн хугацаанд дахин мэдүүлж баталгаажуулсан. Тус газраас "Хасхом" гаргах албан тушаалтны жагсаалтаас хасах болон нэмэх саналтай албан тушаалтны судалгааг гаргаж хүргүүлсэн. Судалгаанд хасах саналтай 1, нэмэх саналтай 1 албан хаагчдын мэдээллийг хүргүүлсэн. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 2018 оны тайлан маягтын дагуу гаргаж 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/125 тоот албан бичгээр хүргүүлэв. Тус газраас "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2019 оны ажлын төлөвлөгөө"-г батлуулсан. Хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар дүгнэж НЗДТГ-т хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай төсвийн шууд захирагчийн байгуулсан үр дүнгийн гэрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлуудыг тусгасан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2019 онд хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг боловсруулан баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд:

- Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээллийг тухай бүр www.shilendans.gov.mn шилэн дансанд оруулж ажиллаж байна.
- Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдлүүлэгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилож байна.

- Байгууллагын хэмжээнд ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдлөг болгон ажиллаж байна.
- Тус газрын хэмжээнд өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.



Тус газраас авлигын эсрэг хууль, тогтоомж, дүрэм журмыг сурталчлах, авилгыг үл тэвчихийг иргэн бүрт төлөвшүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газраас www.iaac.mn цахим сайтаас сэдэвчилсэн видео сурталчилгаа, контентыг өөрийн байгууллагын http://nsug.ub.gov.mn цахим сайтад байршуулан олон нийтэд түгээж сурталчлан ажилласан. Мөн ажилтан, албан хаагчдын цахим хаягаар сурталчилсан.

*Байгууллагын ажилтан албан хаагчдын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, сахилга хариуцлагыг өндөржүүлэх төлөвлөгөө гарган ажиллах;*



Тус газраас 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 12 чиглэлээр ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулахаар төлөвлөгөө гаргаж батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу 2019 оны 1, 3, 5 дугаар сард 3 удаагийн харьяа соёлын байгууллагууд болон дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулсан. Тус газраас 2019 оны 01 дүгээр сард Харьяа соёлын байгууллагууд болон дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, уг сургалтад оролцсон ажилтан, албан хаагчдаас сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг авч ажилласан. Тус төлөвлөгөөний дагуу 2019 оны 1, 3, 5 дугаар сард 3 удаагийн харьяа соёлын байгууллагууд болон дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:



- Тус газраас "Нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавхи бэхжүүлэх хөтөлбөр"-ийн дагуу зохион байгуулагдах сургалтуудад Судалгааны арга зүй, Excel програмын чиглэлээр хамрагдах саналыг НЗДТГ-т хүргүүлсэн.
- Авлигатай тэмцэх газрын төлөвлөгөөт сургалтад Хасхом мэдүүлдэг 3 албан хаагчийг 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хамруулсан.
- Тус газраас 2019 оны 03 дугаар сард Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Т.Баярхүү "Авилгаас урьдчилан сэргийлэх нь" сэдвээр харьяа соёлын байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад сургалт өгсөн. Тус газрын болон Баянзүрх дүүргийн соёлын ордны албан хаагчдад Хүүхдийн эрх хүүхэд хамгаалал, хүүхэдтэй хандах зэрэг хандлагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан



сэргийлэх сургалт, сурталчилгааг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулсан.

- Ажилтныг ажлын байран дээр хөгжүүлэх, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор харьяа байгууллагуудын удирдлага, менежерүүд, газрын мэргэжилтнүүдэд "Эерэг хандлага-бүтээлч сэтгэлгээ", "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замууд", "Үйлчилгээний соёл", "Дотоод хяналтыг төлөвшүүлэх нь" сэдвүүдээр АТГ, МХЕГ, "Корпорэйт трэйнинг" ХХК болон мэргэжлийн багш нартай хамтарсан сургалтуудыг зохион байгуулсан. Мөн 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны нэгдсэн сургалт"-д тус газрын эрх бүхий албан тушаалтан хамрагдсан.
- "Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналтын картыг нэвтрүүлэх нь" сэдэвт НЗДТГ-аас зохион байгуулсан сургалтад 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр холбогдох хэлтсийн мэргэжилтнүүд хамрагдсан.
- Соёлын тухай хуулийн 5.3 дахь заалт, МУ-ын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд угийн бичиг хөтөлдөг айл өрхийн судалгааг шинэчлэн гаргаж 775 өрх бүртгэсэн. Мөн Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын 2019 оны А/15 дугаар тушаалаар 9 дүүргийн хэмжээнд угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэхээр сургалт зохион байгуулах төлөвлөгөө хүргүүлж, нийт 9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд 05 дугаар сарын 03-наас 08-ны хооронд "Монгол толбо" ТББ-ын Хүний их эмч, Э.Энхмаа,Монголчуудын Угийн бичгийн академийн ерөнхийлөгч, судлаач багш, Шинжлэх ухааны доктор Ш.Биндэръяа, академийн сургагч багш, Шинжлэх ухааны доктор Ц.Эрдэнэбат, Түүхч, судлаач Б.Одончимэг, А.Ганболд нартай хамтран "Угийн бичиг хөтлөх арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж ерөнхий боловсролын сургууль болон хороодын нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нийт 225 хүнийг хамруулж, сургагч багшийг бэлдсэн.



Нийслэлийн Соёл, урлагийн газраас харьяа байгууллагууд, тэр дундаа нийслэлийн дүүргүүдийн соёлын ордны дуу, бүжиг, хөгжмийн дугуйлангийн багш нарт зориулсан вакумжуулсан сургалтыг СУИС-тай хамтран тус сургуулийн харьяа "Эгшиглэн" зуны сургалтын төвд 6 дугаар сарын 25-наас 28-ны өдрүүдэд зохион байгуулсан. Дүүргүүдийн соёлын ордны багш нарын чадавхийг сайжруулах, туршлага солилцуулах зорилготой тус сургалтад нийслэлийн 7 дүүргийн соёлын орднуудын 25 багшийг хамруулж байгаа сургалт юм. Нийслэлийн соёл, урлагийн салбарын ажилтан, албан хаагчид, уран бүтээлчдийг чадавхижуулах сургалтуудыг мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулахаар төлөвлөж байна.



Тус газрын харьяа Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Соёлын орднуудын 10 номын санчдад зориулан мэргэшлийн сертифакттай сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 28-аас 12 дугаар сарын 06-ны өдрийг дуустал СУИС-тай хамтран зохион байгуулсан. Нийт 1 450 000 төгрөгний сургалтад хамруулсан.

## 3.2 Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа:

2019 онд шинэчлэгдсэн хууль, тогтоомжийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/28 дугаарын тушаалаар батлагдсан ажлын хэсэг “Байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Мөн 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/29 дугаарын тушаалаар “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “Нийгмийн баталгааны хөтөлбөр”, “Сургалтын хөтөлбөр”-ийг, 2019 оны 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/30 дугаарын тушаалаар “Дотоод журам”, 2019 оны 02 дугаар сарын 25-ны А/08 дугаарын тушаалаар “Ёс зүйн зөвлөл”, 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/31 дугаарын тушаалаар Байгууллагын шагналын журам”-ыг тус тус боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

## 3.3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн ажил:



БНСУ-ын Пусан хоттой байгуулсан санамж бичгийн хүрээг тэлэх зорилгоор тус хотын “Урлагийн байгууллагуудын нэгдсэн холбоо”, “Монголын урлагийн ажилтны холбоо”-ны хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд хоёр хотын дүрслэх урлагийн салбарын уран бүтээлчдийн хамтарсан “Эгч дүүс хотуудын уран бүтээлчдийн хамтарсан үзэсгэлэн”-г “Монголын урчуудын эвлэлийн хороо”-ны дэргэдэх Залуу уран бүтээлчдийн нэгдэлтэй хамтран зохион байгуулсан. БНСУ-ын Пусан хотын урлагийн 57 дахь удаагийн наадамд 2019 оны 10 дугаар сард “Улаанбаатар Чуулга”-ын уран бүтээлчид оролцсон.



Япон Улсын “Япон Монголын бизнесийг дэмжих төв” ТББ-ын төлөөллийг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар хамтран ажиллах асуудлуудыг хэлэлцэж цаашид хэрэгжүүлэх боломжтой хоёр ажилд харилцан санал солилцсон. Монгол Улсад зохиогчийн эрхийг хамгаалах, уран бүтээлчдийг дэмжих чиглэлээр караоке үйлчилгээнд тоолуур бүхий шинэ систем нэвтрүүлэх, Улаанбаатар хотын музейн барилгын сэргээн засварлалт, музейн өргөтгөлийн талаар талууд санал солилцсон.



Солонгосын Элчин сайдын яам, “Краунь-Хэтэ” групп хамтран Рагым Солонгосын үндэсний хөгжмийн “Янжу пүнрюү” чуулгын тоглолтыг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо 06 сарын 19-ны өдөр ДБЭТ-ын тайзнаа амжилттай зохион байгуулсан билээ. Тэгвэл өнөөдөр тус тоглолтыг зохион байгуулсан “Краунь-Хэтэ” групп удирдлагуудтай санал солилцов. Солонгос Улсад ирэх 10 дугаар сард зохион байгуулагдах “Ариранг” ардын урлагийн наадамд Улаанбаатар хотоос төлөөлөл оруулцах мөн соёл, урлагийн бусад чиглэлээр цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо.

Мөн дараах ажлуудыг гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд гүйцэтгэв.

- Улаанбаатар хот болон БНСУ Сөүл хотын найрамдалт харилцааны хүрээнд 2019 оны 07 дугаар сарын 13-ны өдөр “Song and Dance Festival”-ыг зохион байгуулсан.
- Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, ОХУ болон Монгол Улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдол бүхий арга хэмжээ болсон. ОХУ-ын А.В.Александровын нэрэмжит Дуу Бүжгийн Эрдмийн Чуулга

тоглолтоо жанжин Сүхбаатарын талбайд 2019 оны 08.27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан.

*"Хөмөргөн гурвалжин" Бүжгэн жүжиг"*

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн дэмжлэгтэйгээр, Доктор С.Дуламын хадны зургаас сэдэвлэн зохиолыг нь бичсэн "Хөмөргөн гурвалжин" бүжгэн жүжиг Франц Улсын нийслэл Фарис хотод байрлах ЮНЕСКО-ийн төв байранд тоглосон. Тус бүжгэн жүжгийг соёл, урлагийн их сургуулийн багш, оюутнууд 2015 онд олны хүртээл болгосон бөгөөд Монгол Улсад арав гаруй удаа тоглосон бол энэ удаагийн Францын тоглолтод 70 орчим хүний бүрэлдэхүүн оролцож байна. "Хөмөргөн гурвалжин" бүжгэн жүжгийг Соёл урлагийн их сургуулийн багш, бүжиг дэглээч Д.Энхгэрэл найруулж, хөгжмийн зохиолчоор нь "Хөсөгтөн" хамтлагийн ахлагч, хөөмийч Д.Ариунболд ажилласан юм.



**_3.4 Төсвийн шууд захирагчтай нэгжийн менежер, ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж ажиллах чиглэлээр:_**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулахаар төслөөр НЗДТГ-т хүргүүлсэн боловч төсвийн ерөнхий менежер төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулаагүй тул байгууллагын ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулаагүй. Байгууллагын 7 хоногийн тайлан, төлөвлөгөө хугацаанд НЗДТГ-т цахимаар хүргүүлсэн ажиллаж байна.

**_3.5 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, архив ,албан хэрэг хөтлөлтийн байдал:_**

_Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа:_

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архивын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Захиргааны Ерөнхий хууль, Монгол хэлний тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар", Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам", Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар" /цаашид "заавар" гэх/, Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Цахим баримт бичгийн солилцоо" стандарт /MNS ISO 17933:2008/, 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт" /MNS 5140-1:2011, MNS 5140-2:2011, MNS 5140-3:2011/ болон Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамжийн дагуу "Албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам"-ыг байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн акт, энэхүү журмыг дагаж мөрдөж байна.

Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын "UB ERP" дотоод удирдлагын систем систем дэх албан хэрэг хөтлөлтийн EDoc дэд системийг бүрэн ашиглаж байна.

Байгууллагын албан бичгийг шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж, тайлагнаж, албан бичгийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэртээ тусган хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлага, хэлтэс, алба, албан хаагчид тус бүр системд нэвтрэх нэр, нууц үгээр нэвтэрч ирсэн бичгийг шилжүүлэх, баримт бичиг боловсруулах, баримт бичгийн эргэлт хэвийн явагдаж байна.

Баримт бичигт шийдвэрлэх хугацааг заасан, дурдсан хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтөлж байна.

Явуулах бичгийг системд дарааллын дагуу мэдээллийг оруулж системээр явуулах албан бичгийн цахим хувь нь дагалдах нэмэлт файлтай байж болох ба файл нь xlsx, docx, jpg болон бусад өргөтгөлтэйгээр хадгалан цахим програм ашигладаг байгууллагад илгээж ажиллаж байна.

- Байгууллагад ирсэн нийт бичиг 571,
- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр бүртгэгдсэн бичгийн тоо 188,
- Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо 58,
- Системээр бүртгэгдсэн бичгийн тоо 325,
- Хуваарилагдсан бичгийн тоо 571,
- Хуваарилагдаагүй бичгийн тоо 0,
- Хариутай бичгийн тоо 301,
- Хугацаандаа шийдвэрлэгдсэн 262,
- Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 98,
- Хариугүй бичгийн тоо 270,
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1,
- Судалж байгаа 9,
- Явуулсан бичиг 387, хариутай 118, хариугүй 269, цахим edoc системд 100 хувь бүртгэсэн, программ ашигладаг байгууллагуудад илгээж ажилласан.

***Архивын үйл ажиллагаа:***



Нийслэлийн Архивын газраас 2019 оны 02 дугаар сарын 25-ны архив, албан хэрэг хөтлөлт, хариутай бичгийн шийдвэрлэлт, системийн ашиглалт, зэрэг анхаарч ажиллах тухай өгсөн зөвлөмжийн дагуу байгууллагын хэмжээнд цахим нөхөн бүрдүүлэлт, архивын системийн үйл ажиллагаа, тусгай төрлийн баримт бүрдүүлэлт, архивын өрөөний хадгалалт хамгаалалт, ирэн явсан бичгийн бүртгэл хяналт, А,Б тушаалын хавсралт дахь зөрчил, албан бичгийн хугацааны болон танилцах зэрэг заалт тус бүрээр зөрчлийг арилгаж, албан бичгийн зөрчил гаргасан албан хаагчийн жилийн эцсийн үр дүнг үнэлж дүгнэхэд оноо хасах тухай анхааруулж, цаашид зөрлийн түүхийг давтахгүй байх тал дээр анхаарч ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Улсын үзлэг зохион байгуулах тухай" 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Улсын үзэг зохион байгуулах Төв комиссын бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай" 46 дугаар захирамж, Нийслэлийн засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг зохион байгуулах тухай" А/518 дугаар захирамж тус тус шийдвэрүүдийн дагуу байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар баталж, ажлын зохион байгуулалт бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдөр батлуулж, төлөвлөгөөний дагуу ажилтан албан хаагчид улсын үзлэгт бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тус газарт "Улсын үзлэг зохион байгуулах тухай" 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Улсын үзэг зохион байгуулах Төв комиссын бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай" 46 дугаар захирамж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан улсын үзлэгийн хуваарийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн

яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Архивын Ерөнхий газрын улсын ахлах байцаагч Д.Батжаргал, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын рефрент Ю.Оюунжаргал, Архивын Ерөнхий газрын Лавлагаа үйлчилгээний төвийн эрхлэгч С.Шижирбаатар, Нийслэлийн Архивын газрын Мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга, улсын байцаагч Н.Оргилболд нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд улсын үзлэгийг 2019 оны 10 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд явуулсан. Уг үзлэгийн дүнгээр **93 % А** дүгнүүлсэн.

**Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:**

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын "UB ERP" дотоод удирдлагын систем систем дэх албан хэрэг хөтлөлтийн EDoc дэд системийг бүрэн ашиглаж байна. Байгууллагын албан бичгийг шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж, тайлагнаж, албан бичгийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэртээ тусган хэрэгжүүлж байна. Байгууллагын удирдлага, хэлтэс, алба, албан хаагчид тус бүр системд нэвтрэх нэр, нууц үгээр нэвтэрч ирсэн бичгийг шилжүүлэх, баримт бичиг боловсруулах, баримт бичгийн эргэлт хэвийн явагдаж байна. Баримт бичигт шийдвэрлэх хугацааг заасан, дурдсан хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтөлж байна. Явуулах бичгийг системд дараалын дагуу мэдээллийг оруулж системээр явуулах албан бичгийн цахим хувь нь дагалдах нэмэлт файлтай байж болох ба файл нь xlsx, docx, jpg болон бусад өргөтгөлтэйгээр хадгалан цахим програм ашигладаг байгууллагад илгээж ажиллаж байна. Үүнд:

- Байгууллагад нийт ирсэн бичиг 967,
- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр бүртгэгдсэн бичгийн тоо 323,
- Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо 110,
- Системээр бүртгэгдсэн бичгийн тоо 534,
- Хуваарилагдсан бичгийн тоо 967,
- Хуваарилагдаагүй бичгийн тоо 0,
- Хариутай бичгийн тоо 510,
- Хугацаандаа шийдвэрлэгдсэн 484,
- Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 98.89%,
- Хариугүй бичгийн тоо 457,
- Хариугүй бичгийн хаалтын хувь 99.55%
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 11,
- Судалж байгаа 15,
- Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь 99.02%
- Албан бичгийн зөрчлийн тоо нийт 87,
- Зөрчлийн систем ашиглалт 1,
- Шийдвэрлэх хугацааны зөрчил /автомат ажилбараар/ 86,

Явуулсан бичиг 587, хариутай 144, хариугүй 443, цахим edoc системд 100 хувь бүртгэсэн, программ ашигладаг байгууллагуудад 100 хувь илгээж ажилласан.

Иргэдийн удирдлагуудтай уулзах хүсэлт нийт 3, шийдвэрлэсэн. Хугацааны шийдвэрлэлтийн байдал 12 хоног 23 цаг 15 минут байна. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацааг Нийслэлийн зорилтод түвшин /9 хоног 23 цаг 59 минут/-д хүргэж ажиллахыг баримталж байна. Байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг Нийслэлийн зорилтод түвшинд хүргэж ажиллахыг баримталж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, тэмдэглэлийн хамт Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд улирал, хагас, бүтэн жилийн байдлаар хүргүүлж ажиллаж байна.

***3.6 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа:***

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа байхгүй болно.

***3.7. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн байдал:***

*Нэг. Хяналт-шинжилгээ,үнэлгээ, төлөвлөлт:*

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын хүрээнд Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээ гаргах хуваарь, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулан ажиллаж байна.

“Байгууллагын үндсэн чиг үүрэг”, “Гүйцэтгэлийн үзүүлэлт”, “Үзүүлэлтийн дэлгэрэнгүй тодорхойлолт”, “Үзүүлэлтийн 2019 оны зорилт”- ыг тодорхойлон байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн холбогдох мэргэжилтэнд хүргүүлэв.

Байгууллагын үйл ажиллагааны холбогдолтой тайлан мэдээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт - шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг НЗДТГ-ын ХШҮХ-т улирал, хагас бүтэн жилийн байдлаар тайлагнан ажиллаж байна. Мөн тус газрын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт захирамжлалын баримт бичиг ирсэн бөгөөд “L-Monitoring” програмд тайлант хугацаанд биелэлтийг оруулсан..

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

## *4.1. Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал:*




Монгол Улсын 2011 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хууль, Засгийн газрын 2013 оны 411-р тогтоолоор батлагдсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг албан ёсны вэбсайт www.nsug.ub.gov.mn болон фейсбүүк пейж https://Www.facebook.com/ubculture/ хуудсуудаар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Тус газраас байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд илүү хүртээмжтэй, ойлгомжтой хүргэх, мөн нийслэлийн соёл, урлагийн салбарын мэдээллийн санг нэгтгэх зорилгоор "Виртуал ворлд" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, байгууллагын вэб сайт, мэдээллийн санг нэгдсэн байдлаар шинэчлэн ажилласан.

## *4.2. Төсөв, санхүүгийн ил тод байдал*:

Тайлант хугацаанд тус газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2019 оны төсвийн төлөвлөгөө, 2019 оны 1-12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллэгдэж буй мэдээ, тайланг журмын дагуу тус тус байгууллагын цахим хуудас, shilendans.gov.mn сайт, шилэн дансны самбарт байршуулж олон нийтэд мэдээллийг хүргэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Монгол Улсын "Шилэн дансны тухай" хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох" журамд заасны дагуу тайлант хугацаанд багтаан www.shilendans.gov.mn вэб сайт болон байгууллагын шилэн дансны самбарт байршуулж олон нийтэд мэдээллийг хүргэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан. Тус газар болон түүний харьяа байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын тайлан мэдээг авч, төсвийн шууд захирагчид танилцуулан, мэдээллийн самбар болон цахим хуудсанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллагад чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. Тус газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/10 тоот тушаалаар байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг шинэчлэн байгуулж 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган ажиллав. Харьяа байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон үйл ажиллагааны чиглэл, ажлын зохион байгуулалт, төсвийн төсөл боловсруулахаар ажиллаж байна.

Нийслэлийн Соёл, урлагийн газар 1 газрын дарга, 2 хэлтсийн дарга, 1 ахлах мэргэжилтэн, 10 мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд батлагдсан төсвийн дунджаар 65 хувь нь ажилчдын цалин урамшуулал, нийгмийн даатгалд зарцуулагддаг. 2019 оны байдлаар цалингийн сан 147 660 600.00 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 18 457 600.00 төгрөгийг төсөвлөж үйл ажиллагаа явуулж байна. Мөн тус газар Соёл, урлагийг хөгжүүлэх чиглэлд төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 2019 онд 55 160 200.00 төгрөг төсөвлөгдөж батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус газар 2017 онд 451 450 600.00 төгрөг, 2018 онд 369 361 300.00 төгрөг, 2019 онд 650 467 200.00 төгрөгийн төсвийн санал хүргүүлсэн. Тус газар 2017 онд 212 362 200.00 төгрөг, 2018 онд 240 465 500.00 төгрөг, 2019 онд 246 830 800.00 төгрөгийн батлагдсан нь дунджаар төсвийн саналын 50% нь албан ёсоор батлагдсан байгааг харуулсан үзүүлэлт юм.




Тайлант хугацаанд төсөв, санхүүгийн чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Нийслэлийн Соёл, урлагийн салбарын харьяа төсөвт байгууллагуудын 2019 оны батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилж, нийслэлийн төрийн сангаар батлуулан, харьяа байгууллагуудын санхүүжилтийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна.
- Нийслэлийн Соёл, урлагийн салбарын 2018 оны албан ёсны статистикийн мэдээллийг төрийн 13 байгууллага, хувийн хэвшлийн 10 байгууллагыг хамруулан, ҮСГ-ын даргын 2003 оны 114 дүгээр тушаалаар батлагдсан төвлөрсөн мэдээллийн 7 маягт, БСШУС-ын сайдын 221 дүгээр тушаалаар батлагдсан төвлөрсөн бус мэдээллийн 9 маягтын дагуу графикт хугацааны дотор мэдээ гаргуулан нэгтгэн боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2012 оны А/606 дугаар захирамжаар батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
- 2019 оны жилийн эцсийн байдлаар төсвийн гүйцэтгэлийн тайланг сар, улирлаар мэдээллийн самбар болон цахим хуудсанд байрлуулан иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.
- Байгууллагын 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.
- Ажилтан, албан хаагч тус бүрээр хөрөнгийн ашиглалтын бүртгэл нээж хөтлөн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан ажилласан.
- Батлагдсан төсвийг сар, улирлын хуваариар зориулалтын дагуу зарцуулж, төсвийн өр, авлага үүсгэлгүй санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг чанд сахин биелүүлж ажилласан.

## 4.3. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал:

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/635 тоот захирамжаар батлагдсан орон тооны хүрээнд газрын дарга-1, хэлтсийн дарга-2, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-9, нийт 14 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2019 оны жилийн эцсийн байдлаар 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Шинэчлэгдсэн хууль тогтоомжийн дагуу байгууллагын ажилтан, албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийж, шинээр орсон 1 албан хаагчдад хувийн хэрэг нээв. 2019 оны жилийн эцсийн байдлаар 3 ажилтан ажлаас чөлөөлөгдснийг Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ажил хүлээлцэх журам"-ын дагуу ажил хүлээлцүүлж баримтжуулав. Тус газраас Төрийн албаны тухай хууль болон шинэчлэгдэн гарсан холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллаж байна. Тус газарт 3 сул орон тоо гарсаныг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 01/278 тоот албан бичгээр Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн. 1 сул орон тоонд Төрийн албаны тухай хуулийн дагуу шатлан дэвшүүлэх зармаар ажиллаж байгаа нөөцөөс шилжүүлэн ажлуулсан. 2 орон тоог Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ны дагуу түр орлон гүйцэтгүүлэн ажиллаж байна.

| | Ажилтны тоо | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол | Техник, мэргэжлийн | Бакалавр | Магистр | Доктор |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт ажилтан:** | 13 | 0 | 0 | 0 | 1 | 8 | 5 | 0 |
| **Эрэгтэй ажилтан:** | 8 | 0 | 0 | 0 | 1 | 4 | 3 | 0 |
| **Эмэгтэй ажилтан:** | 5 | 0 | 0 | 0 | 0 | 4 | 2 | 0 |




/ 2019 оны байдлаар/

2. Ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг цаг бүртгэлийн төхөөрөмжөөр бүртгэн, гадуур ажлын дэвтэр хөтлөн хяналт тавьж ажиллаж байна. Ээлжийн амралттай болон өвчтэй, чөлөөтэй 137 өдөр, нийт давхардсан тоогоор 5 албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаантай байсныг түр орлон ажиллах ажил үүргийн хуваарийг

гаргаж байгууллагын "Дотоод журам"-ыг баримтлан ажиллав. Ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг 2019 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/03 тоот тушаалаар баталсан.




(2019 оны жилийн эцсийн байдлаар)

3. Тус газрын 8 ахмад ажилтнуудыг сар шинийн баяраар хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулсан.

4. Албан хаагчдын цалин, цалингийн шатлал, ажилласан жилийн нэмэгдлийг цаг тухай бүрт тооцож судалгааг гарган ажилласан. МУ-ын УИХ-ын 21 дугаар "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" тогтоолын дагуу 3 албан, хаагчийн зэрэг дэв ахисан.

5. Хөдөлмөрийн тухай хуулийн 79.2, 79.5, Төрийн албаны тухай хуулийн 61.1.6-д заасны дагуу тус газрын ажилтан, албан хаагчдын 2019 оны ээлжийн амралтын хуваарийг 2019 оны 02 дугаар сарын А/03 тоот тушаалаар батлуулсан.

6. Монгол Улсын Засгийн газрын 33 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн соёл, урлагийн газрын ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдөр боловсруулан батлуулсан. Жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчилгүй ажиллалаа.

7. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулан, 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/08 дугаарын тушаалаар Ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Тус газар нь төрийн үйлчилгээг ил тод, хариуцлагатай байдлаар явуулж, төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр харьяа соёлын байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Салбарын шуурхай зөвлөгөөнийг 2018 оноос хойш 2 сар тутамд 1 удаа зохион байгуулан үүрэг чиглэл өгч ажиллаж хэвшсэн.

8. Тус газар нь шинэчлэгдсэн хууль, тогтоол шийдвэрийг холбогдох дүрэм, журамдаа тусган баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хуучин мөрдөгдөж байсан дүрэм, журмыг хүчингүй болгож, байгууллагын цахим сайтад шинэчлэн байршуулж, иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй үйлчилж байна. Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг 2019 оны 05 дугаар сарын 31-ний А/28 дугаарын тушаалаар байгуулж, Монгол Улсын Засгий газрын 36 дугаар тогтоолоор батлагдсан "Стартеги төлөвлөгөө"-г төслөөр боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулан, 2019 оны 02 дугаар

сарын 25-ны өдрийн А/08 дугаарын тушаалаар Ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Мөн 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/29 дугаарын тушаалаар "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр", "Нийгмийн баталгааны хөтөлбөр", "Сургалтын хөтөлбөр"-ийг, 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/30 дугаарын тушаалаар "Байгууллагын дотоод журам"-ыг тус тус шинэчлэн боловсруулж батлуулсан.Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын дагуу 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/09 дугаар Албан тушаалын тодорхойлолт боловсруулах тухай тушаал, 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/22 дугаарын "Албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай" тушаал батлагдсан ажлын хэсгүүд холбогдох журмын дагуу ажилласан. Тус газрын 13 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлд 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/315 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүнд: Ажлын байрны үндсэн зорилго, зорилт, хууль тогтоомжид тусгагдсан чиг үүргийн нэгжийн чиг үүргүүдийн бүрэн хуваарилагдаж орсон эсэхийг тодорхойлж, давхардал хийдлийг арилгасан. Нэгжийн чиг үүрэг нь тухайн нэгжид харьяалагдах албан тушаалтнуудад албан ёсоор бүрэн хуваарилагдсан. Нэгжийн доторх ажлын ачаалал жигд эсэхийг шинжилж, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой болгосон. Чиг үүрэгт шинжилгээ хийхдээ албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй болович хийгддэг ажлууд, албан тушаалын тодорхойлолтод заагдсан болович хийгдээгүй ажил байгаа эсэхийг тодорхойлж, тухайн албан тушаалын чиг үүргийг бодитой тогтоох арга хэмжээг авсан.

9. 2019 оны жилийн эцсийн байдлаар Соёл, урлагийг хөгжүүлэх түгээн дэлгэрүүлэх үйлст амжилт гаргасан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын шагнал Соёлын тэргүүний ажилтан тэмдэгээр 21, БСШУСЯ-ны жууз бичгээр 7, НИТХ-ийн хүндэт өргөмжлөлөөр 4, Нийслэлийн Соёл, урлагийн газрын "Өргөмжлөл"-өөр 21 уран бүтээлчийг холбогдох журмын дагуу шагнаж урамшуулсан.

10. Тус газрын Хэлстийн дарга М.Мөнхсайхан 500 000, ахмад Д.Мэндсайхан нар хүндээр өвдөж, 500 000 төгрөгний тэтгэмж, С.Дэлгэрмаад мөн адил 500 000 төгрөгийн тэтгэмж, Гэр хороолold амьдардаг 1 албан хаагчид түлээ, нүүрсний 250 000 төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн. Нийт 1 750 000 төгрөгний тэтгэмж олгосон.

11. Тус газар нь ажилчин, албан хаагчдын эрүүл мэнд, чөлөөт цаг, ажил амралтыг үр ашигтай зарцуулах, хамт олны уур амьсгалыг зөв бүрдүүлэх зорилготой соёл, урлагийн харьяа байгууллагуудын дунд спорт өдөрлөгийг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. НСУГ-ын харьяа байгууллагуудын дунд "Спорт өдөрлөг"-ийг 2019 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Багахангай дүүрэгт зохион байгуулсан. Нийслэлийн Соёл, урлагийн газар, харьяа байгууллагуудын спорт өдөрлөг 2019 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Багахангай дүүрэгт 6 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн спорт өдөрлөгт Нийслэлийн Соёл, урлагийн газар, харьяа байгууллагуудын 9 багийн 150 гаруй тамирчид оролцож гар бөмбөг, алсын зайн шидэлт, ширээний шагай гэсэн 3 төрлөөр өрсөлдсөн. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн хүрээнд зохион байгуулсан "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын аяны хүрээнд тус газрын нийт 13 ажилтан, албан хаагчдаас зааврын дагуу сорилыг авсан. Байгууллагын төсөвт эрүүл мэндийн хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлийн төсөв байхгүй улмаас албан хаагчдыг хамруулах боломжгүй байсан. Мөн НСУГ-ын албан хаагчдад Эрүүл зөв, хоололтын сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Сөүл эмнэлэг"-ийн хоол боловсруулах эрхтэн системийн Их эмч зөвлөгөө өгч ажилласан.





12. Тус газар нь ажилтан, албан хаагчдад Эрүүл хооллолт буюу хоол, хүнсээ зөв сонгон, зохистой бэлтгэн хэрэглэж, түүгээрээ дамжуулан таатай мэдрэмж, эрч хүч авах, зөв танин мэдэх, зөв хооллох дадалд суралцах зэрэг зөвлөмж гарган ажилласан. Мөн тус газрын эмэгтэйчүүд долоо хоног болгоны 3 дахь өдрийг цагаан хоол, ногоон хоолны өдөртэй болж хэвшсэн. Мөн эрүүл хоололтын талаарх зөвлөмжийг ажилтан, албан хаагчдад "Seoul" эмнэлэгийн хоол, боловсруулах эрхтэн системийн эмч Б.Буянтогтох зөвлөгөө өгч ажилласан. Тус газраас 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Өнөр үжин эмнэлэгтэй хамтран эрүүл мэндийн 5 төрлийн багц шинжилгээнд 10 албан хаагчийг хамруулсан.

*Хууль,эрх зүйн хүрээнд хэрэгжүүлсэн ажил:*

Тус газар нь Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хүрээнд Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны хуралдааны тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгавар, Иргэдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар авах зарим арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан харьяа соёлын байгууллагуудад хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон. Төрийн албаны тухай хууль болон тогтоол шийдвэрийг холбогдох дүрэм, журамдаа тусган баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хуучин мөрдөгдөж байсан дүрэм, журмыг хүчингүй болгож, байгууллагын цахим сайтад шинэчлэн байршуулж, иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй үйлчилж байна. Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Байгууллагаас гарсан тушаал шийдвэрийн хуулийн үндэслэл заалт тус бүрээр Захиргааны ерөнхий хуулийн дагуу тушаалын төсөлд санал авах хуудсаар хэлстийн дарга газрын даргаас санал авч ажиллаж байна. Мөн харьяа соёлын байгууллагуудад тус хуулийн талаарх мэдээллийг өгч ажилласан.

Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг 2019 оны 05 дугаар сарын 31-ний А/28 дугаарын тушаалаар байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 36 дугаар тогтоолоор батлагдсан "Стартеги төлөвлөгөө"-г төслөөр боловсруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулан, 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/08 дугаарын тушаалаар Ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Мөн 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/29 дугаарын тушаалаар "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр", "Нийгмийн баталгааны хөтөлбөр", "Сургалтын хөтөлбөр"-ийг, 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/30 дугаарын тушаалаар "Байгууллагын дотоод журам"-ыг тус тус шинэчлэн боловсруулж батлуулж ажилласан.

Хүснэгт 4: МУ-ын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралт

## ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал | | | |
| 1. | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143, 2017 оны 89 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралтуудын дагуу байгууллагын цахим хуудсыг тогтмол, хэвийн ажиллуулж, холбогдох мэдээллийг тухай бүрт шинэчлэн, иргэдийг ил тод, нээлттэй мэдээллээр хангаж ажиллаж байна. Мөн Засгийн газрын 2013 оны 411 дугаар тогтоолоор батлагдсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг албан ёсны вэбсайт www.nsug.ub.gov.mn болон фейсбүүк пейж https://www.facebook.com/ubculture/ хуудсуудаар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна Тус газрын http://nsug.ub.gov.mn цахим хуудсаар хэрэглэгчдийн дунд үйл ажиллагааны нээлттэй байдал, хэрэгжүүлсэн ажил, мэдээ мэдээллийг тогтмол оруулж хэвшлээ. 2019 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын цахим хуудсанд давхардсан тоогоор 590869 зочин зочилж, Facebook хуудсанд 11819 дагагчтай, үйл ажиллагааны мэдээг тухай бүр түгээснээс гадна байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь шинэчлэн вэб сайтын мэдээллийн санд тогтмол байршуулж, нийтэд хүргэж байна. Тайлант хугацаанд газрын даргын А тушаал 59, Б тушаал 33 гарсныг цахим хуудсанд 100% байршуулсан.<br>Мөн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааны мэдээлэл, хүний нөөц, төсөв санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь шинэчлэн байгууллагын http://nsug.ub.gov.mn вэб сайтын мэдээллийн санд тогтмол байршуулж, мэдээллийг цахим хэлбэрээр тогтмол үзүүлж олон нийтэд хүргэж байна. http://nsug.ub.gov.mn вэб сайтын мэдээллийн санд тогтмол байршуулж байна. мэдээллийг цахим хэлбэрээр тогтмол үзүүлж олон нийтэд хүргэж байна. 2019 онд шинэчлэгдсэн хууль, тогтоомжийн дагуу 2019 оны 05 | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | дугаар сарын 31-ний өдрийн А/28 дугаарын тушаалаар батлагдсан ажлын хэсэг "Байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Мөн 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/29 дугаарын тушаалаар "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр", "Нийгмийн баталгааны хөтөлбөр", "Сургалтын хөтөлбөр"-ийг, 2019 оны 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/30 дугаарын тушаалаар "Дотоод журам", 2019 оны 02 дугаар сарын 25-ны А/08 дугаарын тушаалаар "Ёс зүйн зөвлөл", 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/31 дугаарын тушаалаар Байгууллагын шагналын журам"-ыг тус тус боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | |
| 2. | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Байгууллагын ажилтан, албан хаагчдын холбогдох мэдээллүүдийг байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд тогтмол байрлуулан, тухай бүрт шинэчлэн ажиллаж байна. Мөн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө болон 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/18 дугаарын тушаалаар батлагдсан "Дотоод журам", цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан. | 100% |
| 3. | Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус газраас НИТХ-ын 2016 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан "Соёл урлагийн сургалт, цэнгээнт үйлчилгээний журам"-ын дагуу үйлчилгээ эрхлэх хүсэлтэй ААНБ-ын хүсэлтийг НҮНТ-өөр дамжуулан авч журмын шаардлага хангасан ААНБ-д Соёл, урлагийн сургалт, цэнгээнт үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгодог. Уг зөвшөөрлийн гэрчилгээг авахад аж ахуйн нэгжийн бүрдүүлэх материалыг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд байрлуулан, тухай бүр шинэчлэн ажиллаж байна. | 100% |
| 4. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус газар нь соёлын чиглэлээр гарсан хууль тогтоомжуудыг сайтад байршуулж ажилтан, албан хаагчид болон иргэдийг нээлттэй мэдээлэл авах боломж нөхцөлөөр хангаж, цаг тухай бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 5. | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; | “Шилэн дансны тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журамд заасны дагуу тайлант хугацаанд багтаан www.shilendans.gov.mn вэб сайт болон байгууллагын шилэн данс болон мэдээллийн самбарт Захиргааны хэм хэмжээний актын шийдвэр төсөл болон хүний нөөц, төсөв санхүүгийн илт тод байдлыг хангаж тухай бүр шинэчлэн байршуулсан. Мөн Нийслэлийн Засаг даргын 2012 оны Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 606“ дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100% |
| 6. | Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | Тус газраас НҮНТ-өөр үзүүлж байгаа НИТХ-ын 35 дугаар тогтоолын дагуу аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт болон өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэн төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай, иргэдэд нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллаж байна. | 100% |
| 7. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; | Тус газар нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэн ажиллаж байна. | 100% |
| 8. | Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус газраас НИТХ-ын 2016 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Соёл урлагийн сургалт, цэнгээнт үйлчилгээний журам”-ын дагуу үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгодог. Уг зөвшөөрлийн гэрчилгээг аван үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-уудын жагсаалтыг цахим хуудсанд байрлуулан, тухай бүр шинэчлэн ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 9. | Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тайлант хугацаанд тус газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2019 оны төсвийн төлөвлөгөө, 2019 оны 1-12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэгдэж буй мэдээ, тайланг журмын дагуу тус тус байгууллагын цахим хуудас, shilendans.gov.mn сайт, шилэн дансны самбарт байршуулж олон нийтэд мэдээллийг хүргэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаан ажиллаж байна. Монгол Улсын "Шилэн дансны тухай" хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох" журамд заасны дагуу тайлант хугацаанд багтаан Www.shilendans.gov.mn веб сайт болон байгууллагын шилэн дансны самбарт байршуулж олон нийтэд мэдээллийг хүргэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаан ажилласан. Батлагдсан төсвийн дунджаар 65 хувь нь ажилчдийн цалин урамшуулал, нийгмийн даатгалд зарцуулагддаг. 2019 оны байдлаар цалингийн сан 147 660 600.00 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 18 457 600.00 төгрөгийг төсөвлөж үйл ажиллагаа явуулж байна. Мөн тус газар Соёл, урлагийг хөнжүүлэх чиглэлд төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 2019 онд 55 160 200.00 төгрөг төсөвлөгдөж батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.Тус газар 2017 онд 451 450 600.00 төгрөг, 2018 онд 369 361 300.00 төгрөг, 2019 онд 650 467 200.00 төгрөгийн төсвийн санал хүргүүлсэн. Тус газар 2017 онд 212 362 200.00 төгрөг, 2018 онд 240 465 500.00 төгрөг, 2019 онд 246 830 800.00 төгрөгийн батлагдсан нь дунджаар төсвийн саналын 50% нь албан ёсоор батлагдсан байгааг харуулсан үзүүлэлт юм. | 100% |
| **Хэсгийн дундаж хувь:** | | | **100%** |
| **Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;** | | | |
| 1. | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах; | Байгууллагын ажилтан, албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийж, шинээр орсон 1 албан хаагчдад хувийн хэрэг нээв. 2 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчдыг Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ажил хүлээлцэх журам"-ын дагуу ажил хүлээлцүүлсэн. Тус газраас Төрийн албаны тухай хууль болон шинэчлэгдэн гарсан холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллаж байна. Тус газарт 3 сул орон тоо гарсаныг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 01/278 тоот албан бичгээр Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн. 2 сул орон тоог Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ны дагуу түр орлон гүйцэтгүүлэн ажиллаж байна. | |
| 2. | Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Монгол Улсын Засгийн газрын 33 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн соёл, урлагийн газрын ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдөр боловсруулан батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулан, 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/08 дугаарын тушаалаар Ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Тус газар нь төрийн үйлчилгээг ил тод, хариуцлагатай байдлаар явуулж, төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр харьяа соёлын байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Салбарын шуурхай зөвлөгөөнийг 2018 оноос хойш 2 сар тутамд 1 удаа зохион байгуулан үүрэг чиглэл өгч ажиллаж хэвшсэн. | 100% |
| 3. | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | 2019 онд шинэчлэгдсэн хууль, тогтоомжийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/28 дугаарын тушаалаар батлагдсан ажлын хэсэг “Байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Мөн 2019 оны 05 дугаар сарын 31-ний өд/рийн А/29 дугаарын тушаалаар “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “Нийгмийн баталгааны хөтөлбөр”, “Сургалтын хөтөлбөр”-ийг, 2019 оны 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/30 дугаарын тушаалаар “Дотоод журам”, 2019 оны 02 дугаар сарын 25-ны А/08 дугаарын тушаалаар “Ёс зүйн зөвлөл”, 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/31 дугаарын тушаалаар Байгууллагын шагналын журам”-ыг тус тус боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 100% |
| 4. | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг ханган ажиллах зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу тус газрын вэбсайтад тус газрын хүний нөөцийн талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр болон сар бүрээр нийтлэн олон нийтэд түгээн ажиллаж байна. | 100% |
| 5. | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан НЗДТГ- т хүргүүлсэн. Шагнал урамшуулал цалингийн шатлал ахиулах, байгууллагын дотоод журамд заасны дагуу урамшуулахаар төлөвлөж, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан байрлуулан мэдээллэн ажиллаж байна. | 100% |
| **Хэсгийн дундаж хувь:** | | | **100%** |
| **Хэрэгжилтийн дундаж хувь:** | | | **100%** |

# ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗААЛТЫН 2019 ОНЫ ЖИЛИЙ ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

| Зорилт | № | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин /Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ/ | Зарцуулсан хөрөнгө | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.Хүний нөөцийг чадавхжуулах | 1.<br>2. | Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт<br><br>Мэргэшсэн туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт | Дотоод сургалтын тоо<br><br>Албан хаагчдын хамрагдсан байдал<br><br>Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал боловсон хүчний мэргэшсэн үзүүлэлт | 5-аас дээш<br><br>80 хувиас дээш<br><br>20 хувиас дээш | 1. Дээд газраас 2019 онд зохион байгуулсан сургалтуудад Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох журмын тухай нийт 8 удаагийн сургалтад 3 удирдах албан хаагч хамрагдсан. Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Чингэлтэй, Багахангай, Багануур дүүргүүд 05 дугаар сарын 03-аас 06 дугаар сарын 05-ны хооронд "Монгол толбо" ТББ-ын АУД, Хүний их эмч, Э.Энхмаа, Монголчуудын Угийн бичгийн академийн ерөнхийлөгч, судлаач багш, Шинжлэх ухааны доктор Ш.Биндэръяа, академийн сургагч багш, Шинжлэх ухааны доктор Ц.Эрдэнэбат, Түүхч, судлаач Б.Одончимэг, А.Ганболд нартай хамтран "Угийн бичиг хөтлөх арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж ерөнхий боловсролын сургууль болон хороодын нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нийт 309 хүнийг хамруулж, сургагч багшийг бэлтгэсэн.<br><br>2.Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр болон 2019 онд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу тус газрын албан хаагчдын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхийг нь сайжруулах чиглэлээр 12 төрлийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс 9 төрлийн сургалтыг зохион байгуулж нийт 200 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдсан. "Нийслэлийн Соёл, урлагийн салбарын | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдах ажилтнуудыг чадавхжуулах сургалт"-ыг 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Чингэлтэй дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан. Тус сургалтад нийт 50 гаруй удирдах болон менежер, дүүргүүдийн мэргэжилтнүүд хамрагдаж 12 чиглэлээр сургалт авсан. Мөн "Номоо солилцъё" төслийн хүрээнд ШШГЕГ-ын харьяа Хорих 405 дугаар ангитай хамтран "Хамтарсан соёлын өдөрлөг"-ийг 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалтад хамрагдсан. Тус сургалтад 2 байгууллагын нийт 80 гаруй албан хаагчид оролцсон. БСШУСЯ болон СУИС-тай хамтран зохион байгуулсан "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2019" эрдэм шинжилгээ- онол практикийн хурлыг 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдөр хамтран зохион байгуулсан. Дээд газар болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын сургалтуудад нийт давхардсан тоогоор 10 гаруй албан хаагчид хамрагдсан байна. Тус газрын захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Дариймаа нь 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ний өдрийн хооронд "Нийгмийн шинжлэх ухааны бизнесийн менежментийн сүүлийн үеийн чиг хандлага" сэдэвт Олон Улсын бага хуралд оролцсон. Нийслэлийн 7 дүүргийн соёлын ордны 25 багш вакумжуулсан сургалтад хамрагдсан. Тус газрын мэргэжилтэн Э.Лувсанцэрэн нь Монгол Улсын үндэсний статистикийн газрын статистикийн анхан шатны мэргэшүүлэх сертификатны сургалтад хамруулсан. Мөн "БСШУСЯ-аас зохион байгуулсан Соёл, урлагийн байгууллагын тогтвортой хөгжил-удирдахуйн шинэлэг хандлага IV" сургалтад газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, соёлын хэлстийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Дэлгэрмаа, 3 мэргэжилтэн оролцсон. Тус газар нь СУИС-тай хамтран "Номын сан дахь мэдээллийн технологи" кредит тооцох сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 28-12.05-ны өдрийг хүртэл тус газрын харьяа Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Соёлын ордрнуудын номын сангуудын 10 ажилтныг хамруулсан сургалтыг зохион | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан. Тус газрын мэргэжилтэн Б.Мөнгөнтүлхүүр нь 2019 оны 11 дүгээр сарын 25-ний өдөр НЗДТГ-аас зохион байгуулсан хуулийн мэргэжилтнүүдийн зөвлөгөөнд оролцсон. 2019 оны жилийн эцсийн байдлаар дээд газраас зохион байгуулсан 5 удаагийн сургалт, семинар, уулзалт зөвлөлгөөн, хэлэлцүүлэг 3, дотооддоо зохион байгуулсан 9 удаагийн чадавхижуулах сургалт, 2 удаагийн мэргэшүүлэх сертифактны сургалтад нийт давхардсан тоогоор 200 гаруй албан хаагчид хамрагдсан байна. Уйгийн бичгийн сургалтад 309 сургагч багш бэлдсэн байна. Сургалтуудад жилийн эцсийн байдлаар зарцуулсан төсөв 2 841 600 төгрөг зарцуулсан. Уйгийн бичгийн сургалтад 9 000 000 төгрөгний төсөв зарцуулсан. | | |
| | **Хэсэг дундаж:** | | | | | **100 %** | |
| 2. Албан хаадын нийгмий | 3. | Цалинс хөлс, шагнал | Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагдын тоо | Гүйц этгэ лээр | 2019 оны жилийн эцсийн байдлаар Соёл, урлагийг хөгжүүлэх түгээн дэлгэрүүлэх үйлст амжилт гаргасан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| н баталгаа г хангах | | урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл зэрэг дэв, шатлал ахиулах | | хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын шагнал Соёлын тэргүүний ажилтан тэмдэгээр 21, БСШУСЯ-ны жуух бичгээр 7, НИТХ-ийн хүндэт өргөмжлөлөөр 4, Нийслэлийн Соёл, урлагийн газрын "Өргөмжлөл"-өөр 21 уран бүтээлчийг холбогдох журмын дагуу шагнаж урамшуулсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/491 дугаарын захирамжаар 3 албан хаагчийн зэрэг дэв ахисан.<br>МУ-ын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын дагуу албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээний дагуу нэмэгдүүлэн холбогдох тушаал шийдвэрийг гаргасан.<br>2019 онд шинэчлэгдсэн хууль, тогтоомжийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/28 дугаарын тушаалаар батлагдсан ажлын хэсэг "Байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Мөн 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/29 дугаарын тушаалаар "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр", "Нийгмийн баталгааны хөтөлбөр", "Сургалтын хөтөлбөр"-ийг, 2019 оны 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/30 дугаарын тушаалаар "Дотоод журам", 2019 оны 02 дугаар сарын 25-ны А/08 дугаарын тушаалаар "Ёс зүйн зөвлөл", 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/31 дугаарын тушаалаар Байгууллагын шагналын журам"-ыг тус тус боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Жил бүр 2 удаа байгууллагын ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэн 1 600 000 төгрөгний гарын бэлэг дурсгалын зүйл өгсөн. Мөн архив, бичиг хэргийн ажилтан Л.Баяртуяагийн ар гэрт 250 000 төгрөгний түлээ, нүүрсний хөнгөлөлтийн тусламж үзүүлсэн. Газрын 2, ахмад ажилтанд 2 удаа, тэтгэмж 1 750 000 төгрөгний тэтгэмж, биеийн эрүүл мэндийн улмаас цалинтай чөлөөг мэргэжилтэн М.Мөнхсайханд 216 цагийн цалинтай чөлөө олгосон байна. | 100 % | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | 4. | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга | Сэтгэл ханамж 80 хувиас дээш | Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр албан хаагчдын өрөө тасалгааны өнгө үзэмжийг сайжруулан урсгал засвар хийж, хүйтэн сэрүүний нөхцөлд цонх хаалганы дулаан алдалтаас сэргийлэн засвар үйлчилгээг хийж ажилласан. Ажилтан, албан хаагчдыг эрүүл аюулгүй, цэвэр орчин нөхцөлд албан үүргийг гүйцэтгүүлэх зорилт тавьж өрөө тасалгааг цэцэгжүүлэн, чийгтэй цэвэрлэгээг өдөр бүр тогтмол хийлгэж байна. Мөн хүйтэн сэрүүн улиралд ханиад томуу туссан албан хаагчдад чөлөө олгон тархалт, дэгдэлтээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. | 100% | |
| 4. | 5. | | Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх | Гүйцэтгэлээр | 2019 онд төсөв хэмнэхтэй холбоотой албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлж чадаагүй болно. | - | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | 6. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг | | Тус газар нь ажилчин, албан хаагчдын эрүүл мэнд, чөлөөт цаг, ажил амралтыг үр ашигтай зарцуулах, хамт олны уур амьсгалыг зөв бүрдүүлэх зорилготой соёл, урлагийн харьяа байгууллагуудын дунд спорт өдөрлөгийг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. НСУГ-ын харьяа байгууллагуудын дунд "Спорт өдөрлөг"-ийг 2019 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Багахангай дүүрэгт зохион байгуулсан. Нийслэлийн Соёл, урлагийн газар, харьяа байгууллагуудын спорт өдөрлөг 2019 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Багахангай дүүрэгт 6 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн спорт өдөрлөгт Нийслэлийн Соёл, урлагийн газар, харьяа байгууллагуудын 9 багийн 150 гаруй тамирчид оролцож гар бөмбөг, алсын зайн шидэлт, ширээний шагай гэсэн 3 төрлөөр өрсөлдсөн. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн хүрээнд зохион байгуулсан "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын аяны хүрээнд тус газрын нийт 13 ажилтан, албан хаагчдаас зааврын дагуу сорилыг авсан. Байгууллагын төсөвт эрүүл мэндийн хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлийн төсөв байхгүй улмаас албан хаагчдыг хамруулах боломжгүй байсан. Мөн НСУГ-ын албан хаагчдад Эрүүл зөв, хоололтын сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Сөүл эмнэлэг"-ийн хоол боловсруулах эрхтэн системийн Их эмч зөвлөгөө өгч ажилласан. Мөн "Өнөр үжин" эмнэлэгтэй хамтран газрын нийт 10 ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн багцийн шинжилгээнд хамрагдсан. | 100% | |
| | Хэсгийн дүн: | | | | | **100%** | |
| | **НИЙТ ДҮН:** | | | | | **100%** | |

### 4.4. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

Нийслэлийн Соёл, урлагийн газраас “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2018 оны ажлын төлөвлөгөө”-г батлуулсан бөгөөд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай тус газрын төсвийн шууд захирагчийн байгуулсан үр дүнгийн гэрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тодорхой ажлуудыг тусган хэрэгжилтийг ханган, тайланг НЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст тайлант хугацаанд багтаан хүргүүлсэн.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн https://meduuleg.iaac.mn цахим системд 2019 оны I улирлын байдлаар байгууллагаас нийт 4 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ мэдүүлж, баталгаажуулсан бөгөөд 100%-тай мэдүүлж ажилласан. Тус газрын ажилтнууд хуулийн хугацаандаа хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлсэн болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ. НИЙСЛЭЛИЙН ХҮН АМД ҮЗҮҮЛЭХ СОЁЛ, УРЛАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ЧАНАРТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

***5.1. Шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажил:***

***"Нийслэлийн уяачдын баяр"***



Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, Агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалангийн 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Нийслэлийн Алдарт уяач цол олгох тухай" А/22 дугаар тоот захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын үүрэг болгосны дагуу 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 18:00-23:00 цагийн хооронд Сөүл плаза ресторанд зохион байгуулагдсан нийслэлийн уяачдын баярын үйл ажиллагааны урлагийн тоглолтыг тус газрын Урлагийн хэлтсийн дарга Э.Цэнд-Аюуш хариуцан ажилласан бөгөөд нийслэлийн Улаанбаатар чуулгын найруулагч МУСТА П.Урнаагаар ахлуулсан МУГЖ С.Ганзориг, МУГЖ Г.Хонгорзул, МУСТА Ц.Гансүх, дуучин Н.Бямбадорж, морин хуурын дөрвөл зэрэг уран бүтээлчид оролцон амжилттай зохион байгуулсан.



Нийслэлийн Уяачдын баярын үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, Агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч асан С.Батболд, НЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар нар оролцож, нийслэлийн Алдарт уяач болсон эрхэмүүдэд цол тэмдгийг гардуулан өгсөн.

***"Монгол цэргийн өдөр"***

Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойг тэмдэглэх тухай" А/85 дугаар захирамжийн дагуу 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Нийслэлийн Соёлыг төв өргөөнд зохион байгуулан ажиллалаа. Энэхүү өдөрлөгийг нээж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан үг хэлсэн юм. Тус үйл ажиллагаанд Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга, Нийслэлийн Улаанбаатар чуулгын уран бүтээлчдийн хамтарсан тоглолтыг зохион байгууллаа. Тоглолтод Нийслэлийн "Улаанбатар" чуулгаас уртын дуучин МУГЖ Хонгорзул, Үндэсний цөөхүүл хөгжимчид, бүжигчид, бит бокс Рэй, Улаанбаатар циркийн жүжигчид, ЦДБЭЧ-ын гоцлол дуучин МУГЖ Б.Батбаатар, гоцлол дуучин МУГЖ Ч.Баярмаа, ЦДБЭЧ-ын эрэгтэй найрал дуучид, гоцлол дуучин Б.Буян, ЦДБЭЧ-ын бүжигчид уран бүтээлээ хүргэсэн юм.

***"Бидний театр -2019" жүжгийн уралдаан***




Нийслэлийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Боловсролын газар, Монгол Улсын Хүүхэлдэйн театр хамтран "Хүүхдэд ээлтэй Улаанбаатар", "Хүүхдийн насны онцлогт тохирсон хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр"-ийн хүрээнд хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, театрын урлагаар




дамжуулан хөгжлийн үйлчилгээг үзүүлэх, соёл, урлагийн боловсрол олгох, хөгжил, оролцоог дэмжин театрын ирээдүйн үзэгчдийг бэлтгэх зорилгоор “Бидний театр 2019” жүжгийн уралдааныг 2 дахь жилдээ Нийслэлийн дүүргүүдийн дунд зохион байгуулан ажиллалаа. “Бидний театр 2019” жүжгийн уралдаанд дүүрэг тус бүр хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон 1 хүүхдийн жүжиг бэлтгэн оролцож жүжгүүдээ тайзнаа амилуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас жүжгийн багийг бүрдүүлж байгаагаараа энэхүү уралдаан ихээхэн онцлогтой юм. Дүүрэг бүрийн хамгийн шилдэг гэсэн авьяаслаг сурагчдаас бүрдсэн жүжгийн баг өөрийн дүүргийг төлөөлөн бусад дүүргүүдтэй өрсөлдсөн. Жүжгийн уралдаан 2 үе шаттай явагдсан бөгөөд нэгдүгээр шат 2019 оны 04 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, дүүргийн харьяа ерөнхий боловсролын сургууль тус бүрээс 100 сурагчдад үзүүлж шүүлтийн 20 оноог цуглуулсан юм. Дүүрэг тус бүрийн зохион байгуулалтыг дүүргийн Засаг даргын тамгын газрын Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, соёлын ордон, төвүүдтэйгээ хамтран зохион байгуулан Хан-Уул дүүрэг Найруулагч СТА Ц.Жаргалсайхан, зохиолч Ц.Түмэнбаяр “Мэргэнд буусан чоно” Модун жүжиг, Баянзүрх дүүрэг Найруулагч СТА Я.Эрдэнэбал, зохиолч Н.Ганхуяг “Удган модны домог” жүжиг, Баянгол дүүрэг зохиолч, Найруулагч СТА Б.Бат-Өлзий, “Наран ээжийн эрэлд” жүжиг, Багануур дүүрэг Найруулагч Б.Мөнх-Эрдэнэ, зохиолч Ю.Кайнер “Алтан үст охин” жүжиг, Сүхбаатар дүүрэг Найруулагч Т.Ганцогтбаяр, Д.Бямбажаргал, зохиолч Т.Ганцогтбаяр “9а,б” жүжиг, Чингэлтэй дүүрэг Найруулагч МУГЖ Б.Жаргалсайхан, зохиолч Т.Бум-Эрдэнэ “Хайрлахын учир” жүжиг, Сонгинохайрхан дүүрэг зохиолч, Найруулагч Г.Ган-Эрдэнэ И.Буянбилэг, “Захидал” жүжгүүдийг 7 дүүргийн 10 000 гаруй ЕБС-ын сурагчдад үзүүлэн жүжиг эхлэхийн өмнө театрын урлаг, үзэгчдийн соёлын талаар сургалт яриаг зохион байгуулан, хүүхэд хамгааллын дүрмүүдийг жүжгээр дамжуулан хүргэж оноо цуглуулсан. Мөн цахим ертөнцөд Бидний театр пэйж хуудсаар 13032 хүн лайк, шийр хийсэн. Хоёрдугаар шат Монгол Улсын Хүүхэлдэйн театрт 2019 оны 04 дүгээр сарын 22,23-ны өдрүүдэд явагдаж театрын урлагийн мэргэжлийн шүүгчид жүжиг тус бүрт үнэлгээ өгч, шилдэг жүжиг 1, 2, 3 дугаар байр, шилдэг эрэгтэй, эмэгтэй гол болон туслах дүрүүд, шилдэг найруулагчийг тус тус тодруулсан юм. Энэхүү уралдааны шагнал гардуулах ёслол нь 04 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Хүүхэлдэйн театрт зохион байгуулагдаж “Бидний театр 2019” жүжгийн уралдааны шилгүүдээр:

- Шилдэг найруулагчаар “Хайрлахын учир” жүжгээр МУГЖ Б. Жаргалсайхан,
- Шилдэг зохион байгуулагч мэргэжилтэн Баянзүрх дүүргийн мэргэжилтэн Д.Цэцэгмаа,
- Шилдэг эрэгтэй гол дүр Хан-Уул дүүргийн “Мэргэнд буусан чоно” Модун жүжгийн Модуны дүрээр Хан-Уул дүүргийн БУЦС –ын 12а ангийн сурагч М. Хаш-Эрдэнэ,
- Шилдэг эмэгтэй гол дүр Чингэлтэй дүүргийн “Хайрлахын учир” жүжгийн Аялгуугийн дүрээр Чингэлтэй дүүргийн 23 дугаар сургуулийн 12а ангийн сурагч Ж.Наранжаргал,
- Шилдэг эрэгтэй Туслах дүр Хан-Уул дүүргийн “Мэргэнд буусан чоно” Модун жүжгийн Түмэн Шаньюгийн дүрээр Хан-Уул дүүргийн 26 дугаар сургуулийн 11а ангийн сурагч Л.Өсөхбаяр,
- Шилдэг эмэгтэй Туслах дүр Баянгол дүүргийн “Наран ээжийн эрэлд” жүжгийн үнэгний дүрээр Баянгол дүүргийн 77 дугаар сургуулийн 11а ангийн сурагч Т.Хонгорзул
- Тэргүүн байрны шилдэг жүжгээр Чингэлтэй дүүргийн “Хайрлахын учир” жүжиг,
- Дэд байрны жүжгээр Хан-Уул дүүргийн “Мэргэнд буусан чоно” Модун жүжиг,
- Гутгаар байрны жүжгээр Баянгол дүүргийн “Наран ээжийн эрэлд” жүжгүүд шалгарсан юм.

Уралдааны нэрэмжит шагналаар:

- Зохион байгуулагчдын нэрэмжит шагнал Сүхбаатар дүүргийн мэргэжилтэн Б.Алтантулхуур
- Монгол Улсын Хүүхэлдэйн театрын нэрэмжит шагнал Чингэлтэй дүүргийн “Хайрлахын учир” жүжгийн туслах дүрд тоглосон 37-р сургуулийн 11 а ангийн сурагч Т.Эрхэмзэнч
- Шүүгчдийн нэрэмжит шагнал Баянгол дүүргийн “Наран ээжийн эрэлд” жүжгийн гол дүрд тоглосон Монгени цогцолбор сургуулийн 11д ангийн сурагч Э.Долгион нар хүртлээ.

***“Улаанбаатар марафон - 2019” олон улсын гүйлтийн тэмцээн***



Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/440 захирамжийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордоны урд хэсэгт зассан тайзан дээр иргэдэд зориулсан урлагийн тоглолт, бие хаалтын дасгал хөдөлгөөн хийлгэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Тус үйл ажиллагаанд Голден жимийн Зумба фитнессийн баг хамт олон болон дуучин Go man, рэйги дуучин Жи жа нар ая дуугаа хүргэсэн. 300 гаруй иргэд, олон нийт оролцсон.

***“Автомашингүй өдөр”***



Нийслэлийн Засаг даргын А/438 захирамжийн дагуу Эрсдэлгүй - эрүүл амьдрал уриан дор “Автомашингүй өдөрлөг”-ийг зохион байгуулан Нийслэлийн Улаанбаатар Чуулгын хамт олон нээлтийн үеэр 40 минутын урлагийн тоглолт явуулсан. Тус тоглолтонд МУСТА Ж.Буянтогтох, М.Анхтуяа, О.Анхчимэг, Н.Бямбадорж, Бит бокс Н.Нарандэлгэр болон Улаанбаатар чуулгын бүжигчид оролцлоо.

***“Австри – Монголын жазз хөгжмийн өдөрлөг”***

Австрийн элчин сайдын яам, Жазз Лаборатори ТББ-тай хамтран 2019 оны 05 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд “Австри-Монголын жазз хөгжмийн өдрүүд”-ийг зохион байгуулсан. Тус өдөрлөгийн хүрээнд зохион байгуулсан Сүхбаатар дүүрэгт байрлах Битлзийн хөшөөний өмнө 2019 оны 05 дугаар сарын 25-нд нээлтэй өдөрлөгт дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Энэхүү арга хэмжээнд Австри Улсыг төлөөлөн саксафон хөгжимчин Лукас Габрич, Унгир Улсаас төгөлдөр хуурч Матиаш Барта, Герман Улсын контробасс хөгжимчин Мартен Зенкер болон Монгол Улсыг төлөөлж Мюнхэнийн Театр Хөгжмийн их сургуулийн жазз бөмбөрийн 1 дүгээр курсын оюутан Б.Хүслэн, The jazz Train хамтлаг уригдан тоглосон.



***"Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан "МОНГОЛ ХҮҮХДҮҮД" баярын үйл ажиллагаа"***



Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/409 захирамжийн дагуу Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг удирдан "Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг 67 дахь жилдээ амжилттай тэмдэглэн өнгөрүүллээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 60 дугаар зарлигийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас Хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор "2019-2020 оныг Хүүхдийн хөгжил, хамгааллын жил" болгон зарласны хүрээнд тус баярын өдөр хүүхдийн эрхийг хүндэтгэх, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр тайзны зүүн талд засагдсан асрууд Төрийн болон төрийн бус байгууллагууд мэдээлэл сурталчилгаа олон нийтэд хүргэсэн. Тус өдрийн төв талбайн үйл ажиллагааг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монгол Улсын Хүүхэлдэйн театр хамтран "Монгол хүүхдүүд" сэдвийн хүрээнд 11:00-17:00 цагийн хооронд зохион байгууллаа. Баярын нээлтийн үйл ажиллагааны ерөнхий найруулагчаар Монгол Улсын Хүүхэлдэйн театрын найруулагч Ариунтуяа, тайзны засал чимэглэлийн Атар арт ХХК, уран бүтээлчдийн бэлтгэл зохион байгуулалтыг Өнөмөнхлэй энтертайнмент ХХК нар хариуцан ажилласан. Тайзны тоног төхөөрөмж, лед дэлгэцийг Шоутеч ХХК, хөгжим апратурыг Жи Си соундс ХХК нараас тус тус түрээслэсэн. Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/25 дугаар тушаалын дагуу 132 425 000 төгрөгийг зарцуулсан.






"Монгол Хүүхдүүд" баярын нээлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн У.Хүрэлсүх, УИХ, Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Р.Дагва, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн С.Амарсайхан болон нийслэлийн иргэдийн хурлын Тэргүүлэгч, Төлөөлөгчид, нийслэлийн төр захиргааны байгууллагуудын удирдлагууд, хүүхэд, гэр бүлийн чиглэлд үйл ажиллагаагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус

байгууллагууд, олон улсын байгууллагуудын удирдлагууд, төлөөлөл, иргэд, хүүхэд багачууд оролцлоо.

Энэ жилийн хүүхдийн баярын нэгдсэн үйл ажиллагааны тоглолтонд нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, байгууллагуудын 1500 орчим уран бүтээлчид, авьяаслаг хүүхэд багачууд оролцож тайзнаа уран бүтээлээ үзүүллээ. Мөн Д.Сүхбаатарын хөшөөний баруун болон зүүн талуудад байрласан асруудад Монголын үндэсний үйлдвэрлэгчид өөрсдийн үзэсгэлэн худалдаагаа гаргаж, төрийн болон олон нийт, хувийн хэвшлийн байгууллагуудаас хүүхдийн өөрийн оролцоонд суурилсан уралдаан наадам, хөгжөөнт тоглоом, хүүхдийн эрхийн талаарх мэдээлэл, сурталчилгаа хийж үйл ажиллагаа явуулсан юм. Түүнчлэн баярын нэгдсэн үйл ажиллагаа, хүндэтгэлийн тоглолтыг Монголын Үндэсний Олон Нийтийн телевиз, UBS телевиз орон даяар шууд дамжуулж үзэгчдэд хүргэсэн билээ.

***"Улаанбаатар хотын бүжгийн спортын аварга шалгаруулах тэмцээн"***

Нийслэлийн Засаг даргын А/479 дүгээр захирамжийн дагуу "Улаанбаатар хотын спорт бүжгийн аварга шалгаруулах" тэмцээний анхан шатны шалгаруулалтыг 05 дугаар сард дүүргүүдэд зохион байгуулсан. Тус тэмцээний эцсийн шатны шалгаруулалтыг 06 дугаар сарын 08-ны өдөр Алдар спортын хороонд зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаа оролцож нийт баг тамирчидад баяр хүргэж нээж үг хэлсэн. Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн нь 2013 оноос эхлэн хосын төрлөөс гадна формейшн буюу хамтлагийн төрөлд зохион байгуулагдаж эхэлснээс тэмцээний нийт оролцогчдын тоо өсөж энэ жил 400 гаруй оролцогчид өрсөлдлөө. Энэ жилийн онцлог нь ОХУ-ын спорт бүжгийн дэд аварга Илья Белобородов, Виктория Кочкина нар урилгаар хүрэлцэн ирж бүжгийн спортын шоу бүжгийн "Хүн бүр дурлаж болно", "Анна Каренина", "Хувь хүний өөрчлөлт" үзүүлбэрүүдээ толилуулсан. Улаанбаатар хотын бүжгийн спортын АШТ-ий гуравдугаар хэсэг буюу зэрэглэлийн тэмцээнүүд Хүүхэд-1 насны Е 6 бүжиг, Хүүхэд-2 насны D 8 бүжиг, Өсвөр-1 насны нээлттэй стандарт, латин, Өсвөр-2 насны нээлттэй стандарт, латин, Залуучуудын нээлттэй стандарт, латин, Ахмад нас нээлттэй стандарт, Насанд хүрэгчдийн нээлттэй стандарт, латин төрлүүдэд амжилттай зохион байгуулагдаж аваргуудаа тодруулсан. МБСХ 2019 оны Улаанбаатар хотын спорт бүжгийн аварга шалгаруулах тэмцээнээ зохион байгуулахын өмнө нийслэлийн алслагдсан 3 дүүргээс бусад бүх дүүргүүдийн Аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулж, мөн тус дүүргүүдэд багш-дасгалжуулагчдын сургалтыг амжилттай зохион байгуулан бүжгийн спорт, үнэн зөв цэнгээнт бүжгийг хөгжүүлэх үндэс суурийг тавьсан. 17 дахь удаагаа зохион байгуулагдаж байгаа Улаанбаатар хотын бүжгийн спортын аварга шалгаруулах тэмцээнийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Спортын хороо, Монголын бүжгийн спортын холбоо ТББ-тэй хамтран зохион байгуулан ажиллалаа.



***"Азийн ардын урлагийн их наадам"***

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/804 тоот тушаалаар Ардын урлагийн шилдгүүдийг шалгаруулах Азийн анхдугаар наадмыг 2019 оны 06 дугаар сарын 12-ноос 16-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Энэ ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүрэгт чиглэл өгч ажилласан ба гоцлол , цөөхүүл , хамтлаг болон найрал дууны, язгуур урлаг гэсэн төрлүүдээр давхардсан тоогоор нийт 373 оролцогч тус наадамд оролцохоор бүртгүүлээд байна. Нийслэлийн 8 дүүргээс Гоцлол , Цөөхүүл , Хамтлаг

болон найрал дууны, Язгуур урлаг гэсэн төрлүүдээр давхардсан тоогоор нийт 373 оролцогч оролцсон.

***"Номоо солилцъё" өдөрлөг***

Нийслэлийн Соёл, урлагийн газраас санаачлан 2017 оноос эхлэн сар бүрийн эхний долоо хоногийн Бямба гарагуудад Д. Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, "JCI Их хүрээ салбар" хамтран "Номоо солилцъё" өдөрлөгийг Д.Сүхбаатарын талбайд нийт 30 удаагаа зохион байгуулсан. Тус өдөрлөгийг иргэдэд уншсан номоо бусадтай хуваалцах, номоор дамжуулан танилцан нөхөрлөх, номын тухай ярилцах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ номын худалдаа зохион байгуулах зорилгоор зохион байгуулан ажиллаж байна. Өдөрлөгийн үйл ажиллагааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол мэдээллэж ажилласан.



***Номын сан хоорондын ном солилцоогоор:***

Тус газрын харьяа Улаанбаатар хотын нийтийн төв номын сан 2019 оны жилийн эцсийн байдлаар 11 удаа 861 номоор номын сан хооронд түр солилцоо хийжээ. Үүнд:

- Их засаг Олон улсын их сургуулийн номын сантай хамтран 30 ширхэг ном,
- Идэр дээд сургуулийн номын сантай 58 ширхэг ном,
- Шинэ Иргэншил дээд сургуулийн МСҮТ-д 30 ширхэг ном,
- Отгонтэнгэр их сургуультай 32 ширхэг ном,
- Улаанбаатар хотын музейтэй 4 ширхэг ном,
- Алслагдсан дүүрэг Багахангай дүүргийн Соёлын ордны нийтийн номын сантай 2 дахь жилдээ 24 ном,
- Өргөө амаржих газрын номын сантай 35 ширхэг ном,
- Ач АУДСургуулийн номын сантай 110 ширхэг ном,
- Зохиомж дээд сургуулийн номын сантай 40 ширхэг ном,
- Шилдэг дунд сургуулийн номын сантай 35 ширхэг ном,
- СУИС-ийн Театр урлагийн сургуулийн номын сантай 21 ширхэг ном,
- СХД-ийн Ерөнхий боловсролын 107 дугаар сургуульд 50 ширхэг ном,
- СХД-н Ирээдүй цогцолбор 86 дугаар сургуульд 42 ширхэг боть ном,
- СХД-н Ерөнхий боловсролын 81 дүгээр сургуульд 12 ширхэг номоор,
- "Хайрын билэг" хүүхдийн зусланд 20 ширхэг боть ном гэх мэт



***"Улаанбаатарын үдэш – эх орноо хамтдаа дуулъя" цэнгүүн***

Тулгар төрийн 2228, Их Монгол Улсын 813, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Үндэсний их баяр наадмын өдрүүдийн нэгэн томоохон соёл, урлагийн арга хэмжээ болох "Улаанбаатарын үдэш-2019" цэнгүүнийг Үндэсний их баяр наадам зохион байгуулах хороотой байгуулсан 2019 оны 07 дугаар сарын 05-ны 19/45 дугаартай гэрээний дагуу 07 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд "Эх орноо хамтдаа дуулъя" сэдвийн хүрээнд жанжин Д.Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгууллаа. Жил бүрийн хөтөлбөр найруулга нь өөр өөрийн гэсэн онцлогтой болдог бөгөөд энэ жилийн хувьд Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 380 жилийн ой давхар тохиож байгаагаараа онцлог болсон, тоглолтод youtube дэх хандалтаараа тэргүүлсэн уран бүтээлүүдийг ихэвчлэн сонгож оруулсан. Тухайлбал: "Авьяаслаг Монголчууд" шоуны оролцогч Б.Шижирбат, "Яг түүн шиг" шоуны оролцогч Б.Халиун, С.Гантогоо, "Voice Mongolia" шоуны оролцогч И.Мөнх-Эрдэнэ, Л.Насанбуян, Б.Одмандах, "Киви" хамтлагийн дуучин Ука, Харанга хамтлагийн дуучин МУГЖ Х.Лхагвасүрэн, 3 охин хамтлагийн дуучин Д.Солонго, ОХУ-ын Буриад Улсын гавъяат жүжигчин Б.Амархүү, Ситара , Assassins crew, Top line бүжгийн хамтлагууд оролцож тайзнаа уран бүтээлээ үзүүлсэн. "Улаанбаатарын үдэш-Эх орноо хамтдаа дуулъя" цэнгүүний ерөнхий найруулагчаар "Буян ХХК"-ын захирал Б.Жаргалсайхан ажилласан.



Мөн БНСУ-ын Сөүл хотын захиргаанаас нийслэл хотын түүхт 380 жилийн ойд бэлэг барьж, Пёнчаны олимпийн наадмын нээлтийн хөтөлбөрт оролцож байсан гэрэлт 100 дрон нисгэж лазер шоу үзүүлбэрийг сонирхуулсан. Тоглолтыг нээж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нээж үг хэлсэн.

Баярын шууд дамжуулалтын ТМ, MASS телевиз албан ёсны эрхтэйгээр шууд дамжуулалт хийсэн. Тус тоглолтыг 15 000 000 гаруй иргэд, жуулчид үзэж сонирхсон юм.

***"Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойн арга хэмжээ"***

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Ой тэмдэглэх тухай" 210 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/350, А/876 дугаар захирамжийн дагуу Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Оросын Армийн А.В.Александровын нэрэмжит дуу, бүжгийн эрдмийн чуулга 08 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод бүрэн хэмжээний тоглолтоо хийсэн.
Тус тоглолтод ОХУ-ын Урлагийн гавьяат зүтгэлтэн, Хойд Осетын Ардын жүжигчин, Уран сайхны удирдаач, Хурандаа Геннадий Саченкюкээр ахлуулсан 132 хүний бүрэлдэхүүнтэй баг хоёр өдрийн турш Соёлын төв өргөөнд 08 дугаар сарын 27-ны 19:00 цаг болон Д.Сүхбаатарын талбайд 08 дугаар сарын 28-ны өдөр 20:00 цагуудад амжилттай тоглосон. 1928 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан тус чуулгын найрал дуу нь дэлхийн шилдэг найрал дууны нэгээр тэмдэглэгдсэн бөгөөд найрал дууны жигдрэл, академик хоолойн тод сэтгэл хөдөлгөсөн цэвэр дуугаралт нь ардын уран бүтээлийн онцлогийг харуулж өндөр чадамжийг илэрхийлж байдаг бөгөөд нийт 2000 гаруй урын сантай, дэлхийд алдартай чуулгын зохион байгуулагч болон анхны хөгжмийн удирдаач нь найрал дууны агуу удирдаач, хөгжмийн зохиолч, Москвагийн Консерваторын профессор, ЗХУ-ын Ардын жүжигчин, ЗХУ-ын урлагийн гавьяат зүтгэлтэн, орчин цагийн Орос болон ЗХУ-ын төрийн дууллын хөгжмийн зохиолч хошууч генерал Александр Васильевич Александр юм.

Мөн Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Монголын Цэргийн дуу бүжгийн чуулгууд буюу Байлдааны гавьяаны болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цэргийн дуу Бүжгийн эрдмийн чуулга, Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Л.Мөрдоржийн нэрэмжит Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулга, ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр хөгжимчид хамтран хүндэтгэлийн тоглолтыг 09 дүгээр сарын 03-нд 21:00 цагт Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулан ажиллалаа. Монгол Улсын Батлан Хамгаалах Яам, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар хамтран зохион байгуулсан бөгөөд тайз засал, лед дэлгэц, үзэгчид, уран бүтээлчдийн сандал, ширээ, хувцасны өлгүүр, асар зэрэг шаардлагатай нэмэлт хэрэгслүүдийг түрээслэн ажил гүйцэтгэх байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан. Тус тоглолтуудыг нийтдээ 10 000 гаруй үзэгчид үзэж сонирхсон юм.



***Нийслэл улаанбаатар хотын анхны шав тавьсан "мэлхийт" хөшөө, "монголын нууц товчоо"-нд хүндэтгэл үзүүлэх, "нийслэлийн сүлдэт хуур" цэнгүүлэх ёслолын ажиллагаа***

Одоогоос 380 жилийн тэртээ 1639 онд Өндөр гэгээн Занабазарыг Их Монголын шарын шашны тэргүүнд өргөмжлөн өргөө байгуулан өгснөөр Монгол улсын нийслэлийн үүслийг тавьсан түүхтэй. Тэр цагаас хойш 28 удаа бууриа сэлгэж, 1778 онд Богдхан уулын ар, хатан Туулын хөвөө, сэрүүн Сэлбийн дэнж, Хүн чулууны хонхорт суурьшихдаа нүүдэллэн ирсний тэмдэг болгож "Хүн чулуун хөшөө"-өөр шав тавьжээ. Энэхүү түүхэн үйл явдлыг мөнхжүүлэх, хойч үедээ таниулан сурталчлах зорилгоор тус шав тавьсан газрын хойд хэсэгт 1994 онд дурсгалын "Мэлхийт" хөшөөг босгож, Нийслэлийнхээ ойгоор хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай болсон юм. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1080 дугаар захирамжийн дагуу Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойг тохиолдуулан нийслэлийн удирдлагууд, нийслэлийн иргэд 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдөр анхны шав тавьсан "Мэлхийт хөшөө"-нд уламжлал ёсоор 12:00 цагт хүндэтгэл үзүүлж, Монголын нууц товчоог залж, нийслэлийн сүлдэт хуураа цэнгүүллээ. Тус ёслолын үйл ажиллагааг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Р.Дагва нээж үг хэлж мэндчилгээ дэвшүүллээ.



Монгол Улсын Ерөнхийлөгч Морин хуур дээдлэн, Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх, "Монголын нууц товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай зарлиг буулгасны дагуу Нийслэлийн Төр захиргааны байгууллагаас "Нийслэлийн Сүлдэт хуур", "Монголын нууц товчоо"-г хүндэтгэлтэйгээр залж жил бүр Нийслэл хотынхоо төрсөн өдрөөр хүндэтгэл үзүүлдэг уламжлалаар Энэ өдөр Нийслэлийн сүлдэт хуурыг Монгол Улсын гавьяат жүжигчин, Монгол Улсын Ардын жүжигчин Ч.Батсайхан цэнгүүлж, Монгол цамын хэсгээс бүжигчид бүжиглэн, Улаанбаатар чуулгын гоцлол дуучин



Монгол Улсын Гавьяат жүжигчин С.Ганзориг “Миний Улаанбаатар” дууг дуулсан юм. Нийслэл хотын ойн энэ түүхэн өдрөөр гал голомтоо бадрааж буй олон хосуудын төлөөлөл болж, хүндэтгэлийн арга хэмжээнд оролцсон хосуудад нийслэлийн удирдлагууд баяр хүргэж, дурсгалын зүйл гардуулсан. “Мэлхийт хөшөө”, Нийслэлийн “Сүлдэт хуур”, “Монголын нууц товчоо”нд Нийслэлийн төр захиргааны байгууллагын удирдлагууд, ажилтнууд, иргэдийн төлөөлөл тойрог хэлбэрээр явж Сүлдэт хуур, Нууц товчоонд хүндэтгэл үзүүллээ. Мөн Мэлхийт хөшөөний тайлбар самбарыг сэргээн засварлан ажиллалаа.

***“Хүүхдийн найрал дуу”***



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, төрийн шагналт Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найралд дууны шилдэг хамтлаг шалгаруулах 27 дахь удаагийн уралдаант наадмыг Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойд зориулан 2019 оны 9 дүгээр сарын 1-ээс 10 дугаар сарын 25- ны өдрүүдэд зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтын чанарыг сайжруулж өсвөр үеийнхэнд гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, хүүхэд бүрийг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулдаг тус уралдааныг жил бүр хоёр үе шаттайгаар зохион байгуулдаг бөгөөд энэ удаагийн наадмын анхан шатны шалгаруулалтад Нийслэлийн 9 дүүргийн 78 сургуулийн 9360 орчим сурагчид 250 гаруй багш авьяас, чадвараа сорин оролцсон бол төгсгөлийн шатны шалгаруулалтад 8 дүүргийн 19 сургуулийн 2800 гаруй сурагчид 53 багш авьяас билэг, ур чадвараа сорин оролцож нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойдоо бэлэг барилаа.

Уралдааны

- 1 дүгээр байранд: Баянгол дүүргийн “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль,
- 2 дугаар байранд: Сонгинохайрхан дүүргийн 62 дугаар сургууль,
- 3 дугаар байранд: Хан-Уул дүүргийн 18 дугаар сургууль,
- Тусгай байранд: Чингэлтэй дүүргийн 50 дугаар сургууль, Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургууль
- Шилдэг удирдаач багшаар: Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургуулийн багш П.Наранцэцэг,
- Шилдэг зохион байгуулалттай сургуулийн захирлаар: Монгол Оросын хамтарсан сургуулийн захирал Ж.Соронзон нар тус тус шалгарлаа.
- Уралдааны хамтран зохион байгуулагчдын шагнал: Урлагийн ажилтны холбооны нэрэмжит шагналаар Налайх дүүргийн 119 дүгээр сургууль, Монголын найрал дууны уран бүтээлчдийн холбооны нэрэмжит шагналаар Баянгол дүүргийн 73 дугаар сургууль, Сүхбаатар дүүргийн 2 дугаар сургууль тус тус шалгарч нэгдсэн гала тоглолтод оролцсон.

Уралдааны анхан шатны шалгаруулалтыг 9 дүүрэг тус бүрээр явж шалгаруулсан бол төгсгөлийн шатны шалгаруулалтыг 2019 оны 10 дугаар сарын 16-нд Монголын хүүхдийн

ордонд, шагналтнуудын нэгдсэн гала тоглолтыг Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойн баярын нэгдсэн үйл ажиллагааны хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 25-нд Нийслэлийн Соёлын төв өргөөнд зохион байгуулав.

***"Улаанбаатарын мөнгөн шөнө" шинэ жилийн цэнгүүн***

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн дагуу нийслэлийн иргэдэд зориулсан "Улаанбаатарын мөнгөн шөнө" шинэ жилийн баярын үйл ажиллагааг Нийслэлийн Засаг даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" А/1240 дугаар захирамж, "Хөрөнгө гаргах тухай" А/1334 дугаар захирамжийн дагуу зохион байгуулан ажиллалаа. Баярын үйл ажиллагааны Сүлд модны гэрэл асаах ёслол болон "Цэвэр агаартай хот" аяны нээлтийг 12 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан.

Захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын А заaланд 2 удаа хурал хийж бэлтгэл зохион байгуулалтын тухай хэлэлцэж, ажлын хэсгийн дарга Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалан баталсан 30 заалт бүхий төлөвлөгөө гарган үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Нэгдсэн төлөвлөгөөний дагуу Нийслэлийн Соёл, урлагийн газар "Улаанбаатарын мөнгөн шөнө" шоу тоглолт болон "Цэвэр агаартай хот" аяны хүрээнд хийгдэж буй мөсөн хотхоны бэлтгэл зохион байгуулалтад хяналт тавин ажиллаж тус газрын мэргэжилтнүүд 2019 оны 12 дугаар сарын 26-31-ны өдрүүдэд бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллалаа.

<u>"Улаанбаатарын Мөнгөн шөнө" шоу тоглолт</u>



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газраас нийслэлийн иргэдэд зориулан "Улаанбаатарын мөнгөн шөнө" шоу тоглолтыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний 18:00-01:00 цагийн хооронд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулан ажиллалаа.

Энэ жилийн шоу тоглолтыг МУСТА Ц.Батнайрамдал найруулж, тоглолтонд Улсын драмын эрдмийн театрын уран бүтээлчид, Монголын хүүхдийн ордны найрал дууны хамтлаг, СУИС-ын театр урлагийн сургуулийн оюутнууд, Монголын нийтийн бүжгийн холбооны бүжигчид, Улсын филармоны симфони найрал хөгжимчид, Цэргийн Дуу бүжгийн эрдмийн чуулга, МҮОНРТ-ийн дэргэдэх "Улаан бүч" чуулгын найрал дуучид, Дуучин С.Наран, МУГЖ Чингис хаан хамтлагийн дуучин Д.Жаргалсайхан, УДБЭТ-ын дуучин МУГЖ С.Мөнгөнцэцэг, МУГЖ Б.Эрдэнэтуяа, МУГЖ Ш.Наранчимэг,МУСТА Б.Гомбо-Очир, МУСТА Д.Батжаргал, Улсын филармоны Баянмонгол чуулгын гоцлол дуучин Б.Дэлгэрбаяр, дуучин Г.Тэмүүжин, "The voice" шоуны шилдэг оролцогч Б.Одмандах, Драм 3, Увертюра, MC collection, Far away, Take off зэрэг хамтлаг дуучид оролцон ая дуугаа хүргэж, өвлийн өвгөнөөр МУГЖ Б.Жаргалсайхан, цасан охидууд, СУИС-ын бүжгийн ангийн оюутан залуус оролцож, хүндэтгэлийн үйл ажиллагааны хөтлөгчөөр МУСГЗ Д.Цоодол, Монгол HD телевизийн нэвтрүүлэгч С.Чимгэээ, шоу үйл ажиллагааны хөтлөгчөөр **МҮОНРТ-ийн хөтлөгч Ц.Шижир** нар хөтлөн явууллаа.



Тус баярын үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан, Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалан, Агаар орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Д.Мөнхжаргал, НИТХ-ын ажлын албаны дарга Б.Батбямба, НЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар болон бусад нийслэлийн удирдлагууд оролцов. Шинэ оноо угтах мөчид Нийслэлийн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан мэндчилгээ дэвшүүлсэн. Тус үйл ажиллагааны үеэр талбайд ААН, байгууллагууд халуун ундаа зууш, шинэ жилийн баярын худалдаа үйлчилгээ гарч, Нийтийн тээврийн газраас үйл ажиллагаа тарсны дараа иргэдийг төв талбайгаас чиглэл бүрт 01 дүгээр сарын 01-ний өдрийн 02:00 цаг хүртэл үнэ төлбөргүй тээвэрлэсэн. Ажлын хэсгийн гишүүд болох Нийслэлийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар зэрэг байгууллагууд нь шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Иргэдийн аюулгүй байдлыг хангах, гудамж талбай, олон нийтийн газарт нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүнс худалдаа үйлчилгээ эрхэлж буй ААН, байгууллагуудад хяналт тавих зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

## ***5.2. Бусад ажлын талаар***

***Урлагийн тоглолт, хурал, уулзалт зохион байгуулдаг байгууллагуудын товч мэдээлэл***

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийг багтаасан гарын авлага гаргаж Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлэх ажлын хүрээнд нийт 24 байгууллагын мэдээллийг бэлтгэж гарын авлагыг хэвлүүлээд байна.




***Нийслэлийн 380 жилийн ойд зориулан улаанбаатар минь" шилдэг уран бүтээлийн хос цомог :***

Тус газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/12 дугаартай тушаалаар Ажлын хэсэг байгуулан хос цомог хийх студийг сонгон шалгаруулах удирдамжийг боловсруулсан. Энэхүү цомгийн ажлын хүрээнд Чингис хаан одонт, Төрийн шагналт, МУУГЗ Б.Шаравын аялгуу, Ардын уран зохиолч, МУСГЗ Т.Галсангийн шүлэг "Тайван энхийн Улаанбаатар" дууг шинэчлэн найруулж Нюанс, Увертюра, Консонанс хамтлагуудаар хоолойн бичлэг хийлгэн бэлтгэл ажлыг эхлүүлсэн. “Улаанбаатар минь” шилдэг уран бүтээлийн хос цомог бүтээх ажлын төсөв, төлөвлөгөөг гарган Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх бүтээлч ажлын төлөвлөгөөнд саналаа хүргүүлсэн болович төлөвлөгөөнд тусгагдаж батлагдаагүй. Ойн төлөвлөгөөнд багтаагүй ч газрын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх үүднээс Засаг даргын Зөвлөх М.Мэнд-Очирт төсөв, төлөвлөгөө, танилцуулгаа

хүргүүлэн дахин ойн төлөвлөгөөнд нэмэлтээр оруулах санал өгсөн боловч санхүүгийн эх үүсвэрийг нь шийдвэрлэх боломжгүй болсон тул тус цомгийн ажил зогссон.

***“Оюуны өмчийг дээдлэн кино урлагаа хамгаалъя аян”***

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар, Монголын кино уран бүтээлийг хамгаалах холбоотой хамтран оюуны өмчийг дээдлэгч Улаанбаатар хотын аяны хүрээнд “Оюуны өмчийг дээдлэн кино урлагаа хамгаалъя аян”-ыг 2019 оны 11 дүгээр сарын 16-30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Аяны хүрээнд телевизийн нэвтрүүлэг, богино хэмжээний реклам, танилцуулгыг байнгын давтамжтай гарган ажилласан.

Тус аяны хүрээнд 11 дүгээр сарын 30-ны 17:00 цагт I CINEMA кино театрт форум хэлэлцүүлэг болж Оюуны өмч, тэр дундаа кино урлагийн салбарт оюуны өмчийн эрх зөрчигдөж байгаа асуудалд мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, кино урлагт оюуны өмчийг хамгаалах нэгдсэн бодлого, боломж, асуудлын шийдлийг эрэлхийлсэн.

Хэлэлцүүлэг форумд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газрын Хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Соёл, урлагийн газрын Соёлын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Дэлгэрмаа, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Соёл, урлагийн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн З.Баянзул, Монголын кино уран бүтээлийг хамгаалах холбооны тэргүүн Д.Сумхүү, гишүүд Монголын шинжлэх ухаан танин мэдэхүй, байгаль орчны кино нийгэмлэгийн тэргүүн, зэрлэг амьтан, байгалийн баримтат кино оператор, найруулагч, МУСГЗ Г.Дарханбаяр, Твинс фильм студийн захирал Н.Ганхуяг, СУИС-ийн багш, МУСГЗ Д.Дэлгэрцоо, Ай пи консалтинг ХХК-ны захирал З.Сүхбаатар, Монгол өмгөөлөгч ХХК-ны захирал Монголын хуульчдын холбооны гишүүн Гантуяа болон бусад гишүүд мөн Өнгөт инээд ХХК-ны захирал Ц.Хүсэлбаатар, Найруулагч Г.Бадамрагчаа, Оюунлаг продакшны захирал найруулагч Б.Отгонбаяр, BIG энтертэймэнт ХХК захирал найруулагч М.Батболд, Монгол фильм ХХК-ны захирал найруулагч Д.Золбаяр нар болон ТВ-үүдын төлөөлөл бусад албаны хүмүүс хүрэлцэн ирж оролцлоо. Кино форумыг нээж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газрын Хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Соёл, урлагийн газрын Соёлын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Дэлгэрмаа, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Соёл, урлагийн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн З.Баянзул нар үг хэллээ. Форумд:

- Соёлын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Дэлгэрмаа Кино урлаг, оюуны өмчийн талаар нийслэлээс хэрэгжүүлж буй бодлого;
- Монголын кино уран бүтээлийг хамгаалах холбооны гүйцэтгэх захирал Д.Төгсөө Киночдын дунд тулгарч буй асуудлууд, тэдгээрийг шийдэх аргачлал;
- Өнгөт инээд ХХК-ны захирал Ц.Хүсэлбаатар, Найруулагч Г.Бадамрагчаа, Оюунлаг продакшны захирал найруулагч Б.Отгонбаяр нар Уран бүтээлээ алдахад гаргах хохирол, хэрхэн хохирлынхоо хойноос хөөцөлдсөн талаар мөн учирч байсан хүндрэл бэрхшээл;
- BIG энтертэймэнт ХХК захирал найруулагч М.Батболд өөрт тохиолдсон асуудал зэрэг сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлэг тавилаа.
- Форумын төгсгөлд хамтран ажилласан байгууллагуудад өргөмжлөл гардуулж, Оюуны өмчийн газар, Монголын кино уран бүтээлийг хамгаалах холбоо хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурж Монгол фильм ХХК-ны захирал найруулагч Д.Золбаяр аяныг хааж уран бүтээлчийн зүгээс сэтгэгдэл үгээ хэлж хэлэлцүүлэг өндөрлөлөө. Энэхүү аяныг дэмжин 16 телевиз, 11 кино студи хамтран ажиллаж цахим хуудсаар 59 823 иргэдэд мэдээллийг хүргэж ажилласан.

***“Соёл, урлагийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг”***

Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй Соёл, урлагийн мэргэжлийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг” 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгуулагдлаа. Нээлтийн ажиллагаанд БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг, Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалан, БСШУС-ын яамны Соёл, урлагийн бодлогын газрын даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч Б.Сэргэлэн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын дарга Г.Эрдэнэбат, Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч Э.Цэнд-Аюуш нар оролцлоо. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төр засгаас соёлын талаар авч хэрэгжүүлж буй бодлого, чиглэлийг таниулах мөн олон нийтэд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулсан.




Энэхүү соёл, урлагийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар хамтран зохион байгууллаа. Уг өдөрлөгт Нийслэлийн соёл, урлагийн газар, Улсын драмын эрдмийн театр, Үндэсний урлагийн их театр, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, Улсын хүүхэлдэйн театр, Улсын филармони, Хүүхдийн төв номын сан, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Монголын үндэсний музей, Богд хааны ордон музей, Байгалийн түүхийн музей, Үлэг гүрвэлийн төв музей, Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музей, Театрын музей, Монгол цэргийн музей, Соёл урлагийн их сургууль, Монгол Улсын Консерватори, Уран зургийн галерей, Улаанбаатар чуулга, Түмэн эх чуулга, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга зэрэг 26 байгууллага оролцож иргэд, олон нийтэд үйл ажиллагаагаа танилцуулсан.



***Нийслэлийн Соёл, урлагийн салбарын 2019 оны үйл ажиллагааны тайлант өдөрлөг***

Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Соёл, урлагийн газраас санаачлан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран “Нийслэлийн соёл, урлагийн байгууллагуудын жилийн ажлын тайлант өдөрлөг”-ийг дүүрэг тус бүрт зохион байгуулж, Нийслэлийн Улаанбаатар чуулга, Нийслэлийн Соёлын төв өргөө, Улаанбаатар хоты н музей зэрэг байгууллагууд 2019 оны 11 дүгээр сарын 08-нд Нийслэлийн Улаанбаатар чуулгын байранд, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан 2019 оны 11 дүгээр сарын 11-нд төв номын сангийн байранд, Нийслэлийн Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Багануур, Багахангай, Налайх, Чингэлтэй дүүргийн Соёлын ордонууд 11 дүгээр сарын 12-21-ны өдрүүдэд соёлын ордондоо тус тус зохион байгууллаа.



Өдөрлөгийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор Нийслэлийн Соёл, урлагийн байгууллагууд 2019 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудаа тайлагнасан үзэсгэлэн гаргаж, урлагийн тоглолтоо зохион байгуулахын зэрэгцээ Нийслэлийн Улаанбаатар чуулгын хамт олон Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойд зориулан бүтээсэн “Их хотын аялгуу” хүндэтгэлийн тоглолтоо тоглох, Улаанбаатар хотын музейн хамт олон ойд зориулан шинээр бүтээсэн “Эрт-эдүгээ-ирээдүйн Улаанбаатар” үзэсгэлэнгээ гаргах, Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн хамт олон номын үзэсгэлэн, худалдаа, хандив зэргийг зохион байгуулсан.

***“Хууртай мөнхрөх аялгуу 2019” уртын дуучдын уралдаан***




2007 оноос хойш Налайх дүүргийн Соёлын ордны санаачилгаар Нийслэлийн Соёл, урлагийн газрын дэмжлэгтэйгээр жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хууртай мөнхрөх аялгуу-2019” уртын дууны уралдааныг 2019 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Налайх дүүргийн Соёлын ордонд зохион байгууллаа.

Энэ удаагийн уралдааныг Төв халхын алдарт уртын дуучин, Соёлын тэргүүний ажилтан Чойжилын Намжилын нэрэмжит болгон гурван насны ангилалаар зохион байгуулав. Уралдаанд нийт 33 уртын дуучид оролцосноос

| | |
|---|---|
| Гран-При шагнал | А.Дуламсүрэн / Хан-Уул дүүрэг/ |
| Бага насны ангилалд: | |
| I байр | Ц.Анужин /Чингэлтэй дүүрэг/ |
| II байр | Х.Нарангарав /Налайх дүүрэг/ |
| III байр | Б.Дашцэцэг /Чингэлтэй дүүрэг/ |
| Тусгай байр | М.Марал / Налайх дүүрэг/ |
| Тусгай байр | Ч.Нандин-Эрдэнэ /Чингэлтэй дүүрэг/ |
| Дунд насны ангилалд: | |
| I байр | Э.Хандсүрэн /Баянзүрх дүүрэг/ |
| II байр | Д.Энхтайван /Баянхонгор аймаг/ |
| III байр | Б.Гантуул /Баянгол дүүрэг / |
| Тусгай байр | З.Мийгар /Баянзүрх дүүрэг/ |
| Тусгай байр | Э.Эрдмаа /Баянхонгор аймаг/ |
| Ахлах насны ангилалд: | |
| I байр | Ц.Мөнхбаяр /Сонгинохайрхан дүүрэг/ |
| II байр | Г.Тамир /Баянгол дүүрэг/ |
| III байр | Д.Дагдан /Баянзүрх дүүрэг/ |

Тусгай байр С.Мажигжаргал / Хан-Уул дүүрэг/
Тусгай байр Ц.Болормаа /Баянзүрх дүүрэг/ нар тус тус шагналт байранд шалгарав.

Уралдааны шүүгчээр СУИС-ийн уртын дууны багш, МУГБ Ц.Дэлгэр, МУГЖ, уртын дуучин Д.Баттөмөр, НСУГ-ын мэргэжилтэн, СТА М.Мөнхсайхан нар ажиллав.

***"Сайжруулсан шахмал түлшний хэрэглээ"***




Нийслэлийн онцгой комиссын 2019 оны 11 дүгээр дүгээр хурлаар "Сайжруулсан шахмал түлшний аюулгүй зөв хэрэглээ, түүхий нүүрсний хэрэглээнд хяналт шалгалт явуулсан дүн, цаашид авах арга хэмжээний асуудал"-ыг хэлэлцээд Нийслэлийн төр захиргааны нийт байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад тодорхой үүрэг даалгавар өгсөн хуваарийн дагуу тус газрын нийт албан хаагчид 2019 оны 12 дугаар сарын 12-ны 09:00 цагаас 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 09:00 цаг хүртэл Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шуурхай штабын байранд болон Баянзүрх дүүргийн 5, 19, 22 дугаар хороонд сайжруулсан түлш худалдаалж буй цэгүүдэд, "Таван толгой түлш" ХХК-ийн үйлдвэрийн байранд газар дээр нь ажиллалаа.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын шуурхай штабад ажиллаж буй албан хаагчид дүүргүүдийн шуурхай штабаас мэдээллийг 09:00, 13:00, 19:00, 23:00, 03:00 цагуудад авч нэгтгэн тухай бүр Нийслэлийн шуурхай штабад хүргүүлэн ажиллалаа.

Баянзүрх дүүргийн 5, 19, 22 дугаар хороодын нийт 31 борлуулах цэгт газар дээр тус газрын ахлах мэргэжилтэн Ө.Бум-Эрдэнэ, мэргэжилтэн Ш.Гомбосүрэн, Э.Лувсанцэрэн, Н.Барманлай, О.Зууннасан, М.Мөнхсайхан нар газар нь очиж ажилласан. Газар дээр нь очиж ажилласан байдлын тухай мэдээллийг хүснэгтлэн мэдээллийг хавсаргав.




Сайжруулсан түлш худалдан борлуулж буй гэрээт ажилтнууд иргэдэд сайжруулсан түлш олгохдоо зөвхөн картаар үйлчилж буй бөгөөд цөөн тохиолдолд 1 шуудай түлшийг картгүйгээр олгож байгаа тухай мэдэгдсэн. Цэг бүр дээр ажиглалт явуулахад худалдан борлуулж буй гэрээт ажилтнууд иргэдэд картаар үйлчилж байсан. Үйл ажиллагаа явуулж буй борлуулалтын цэг дэх сайжруулсан түлшний нийлүүлэлт дунджаар өдөрт 8 тонн ирж буй бөгөөд түлш нийлүүлэх цаг хугацаа тодорхойгүй, нийлүүлэлтийг зөөвөрлөх компани болох "Хийморь" ХХК нь гэрээт ажилтнуудад хүндрэл учруулдаг тухай санал гомдол гаргаж байсан бөгөөд нийтлэг дараах гомдлыг уламжлахыг хүссэн. Үүнд:

1. Гэрээт ажилтнуудад олгох ёстой цалин, урамшуулал 2019 оны 09 дүгээр сараас хойш олгогдоогүй тухай гэрээт ажилтнууд гомдолтой байгаа бөгөөд, үүнээс хамаарч 2 цэг үйл ажиллагаа явуулахаа зогсоосон байна.
2. Сайжруулсан түлшийг тээвэрлэж, хүргэдэг байгууллага нь тодорхой цаг хугацаанд нийлүүлэлтийг хангалтгүй, захиалсан хэмжээнээс багаар нийлүүлдэг.
3. Нийлүүлж буй түлш хог хаягдал их гарч байгаа бөгөөд тухайн хог хаягдлыг зөөвөрлөгч компанид мэдэгдсэн боловч буцаан таталт хийхгүй байгаа нь борлуулагчдад зохиомол өр бий болгох эрсдэл гарч болох тухай уламжлах.
4. Үйлдвэрийн, эсхүл тээвэрлэлтийн буруугаас болж сайжруулсан түлш үйрэх, бутрах, шуудайн доод хэсэгт хаягдал ихтэй байгаа нь гэрээт ажилтан болон иргэдийн хооронд үл ойлголцох байдал үүсгэж буй тухай мэдэгдсэн болно.

Мөн гэрээт борлуулалтын цэгүүдийг байршлын хувьд авч үзвэл төв зам дагуу үйл ажиллагаа явуулж буй цэгүүд дэх түлш өдөртөө дуусч, гэр хороолол дунд байрлах цэгүүдэд түлшний нөөцийн дутагдал үүсээгүй байна.

Иргэдийн зүгээс сүүлийн өдрүүдэд худалдан авч буй шахмал түлш хог ихтэй, бутарсан, уут нь урагдсан тохиолдол ихсэж буй талаар тайланд тусгаж Нийслэлийн онцгой комиссын хуралд мэдэгдэж өгөхийг хүссэн бөгөөд иргэдээс дараах нийтлэг гомдлыг гаргасан болно. Үүнд:

1. Картын үлдэгдэл дууссан тохиолдолд худалдаж буй цэгүүд олгохгүй, мөн картаа хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хэрхэн дахиж карт авах тухай мэдээлэл байхгүй зэрэг карттай холбоотой гомдол гаргасан.
2. 7 хоногт 6 уут түлш олгож байгаа нь иргэдийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байгаа бөгөөд цаг агаарын нөхцөл байдал хүйтрэх үед(Ес эхлэх үед) одоогийн олгож буй түлшний хязгаар нь хүрэлцэхгүй тул 1 өдөрт 2 шуудай түлш олгохоор зохицуулалт хийхийг хүссэн.
3. Хог хаягдал ихтэй байгаа нь иргэдийн худалдаж авсан түлшний хэмжээнд хүрэхгүйгээс болж түлшний хорогдол бий болж байгаа зэрэг асуудлыг нийтлэг байдлаар гаргасан болно.

"Таван толгой түлш" ХХК-ийн үйлдвэрийн байранд тус газрын Урлагийн хэлтсийн дарга Э.Цэнд-Аюуш, ахлах мэргэжилтэн Ө.Бум-Эрдэнэ, мэргэжилтэн Э.Лувсанцэрэн, Н.Барманлай, М.Мөнхсайхан нар ажиллах үеэр иргэд болон гэрээ борлуулагчдаас гаргасан саналыг үйлдвэрийн хариуцлагатай жижүүр Захиргаа борлуулалтын менежер албан тушаалтан М.Бямбадоржид танилцуулсан бөгөөд үйлдвэрлэгч байгууллагаас дараах мэдээллийг өгсөн болно.

Мөн шахмал түлшний нийлүүлэлтийн байдалд хяналт тавьж ажилласан бөгөөд иргэд, гэрээт борлуулагчдын зүгээс гаргасан шахмал түлшний үртэс, үйрмэг их байгаа эсэхэд хяналт тавж ажиллав.

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ — Ч.БАТ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:
СОЁЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — С.ДЭЛГЭРМАА

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ЗАХИРГААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Ө.БУМ-ЭРДЭНЭ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН — Б.МӨНГӨНТҮЛХҮҮР